



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**“2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ”  
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**



*Баянхонгор хот  
2018 оны 11 дүгээр сар*



## Товчилсон Үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

## Хавсралт судалгааны жагсаалт

ОНТГ-Хавсралт №1	Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн судалгаа
ОНТГ-Хавсралт №2	Орон нутгийн төсвийн орлогын судалгаа
ОНТГ-Хавсралт №3	Баянхонгор аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан
ОНТГ-Хавсралт №4	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2018 оны орон тоо, цалингийн сангийн судалгаа
ОНТГ-Хавсралт №5	Гадаад албан томилолтын зардлын судалгаа
ОНТГ-Хавсралт №6	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлэт

## **АУДИТЫН ТАЙЛАН**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 тоот тушаалаар батлагдсан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ:**

Монгол улсын Төсвийн тухай хууль, Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган ҮАГ, аймгийн ИТХ болон ТЕЗ-чид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. /Хавсралт №1/

1. 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх
2. 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
3. 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх
4. ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэн үр дүн, зорилтод түвшинд нийцсэн эсэх.

Аймгийн ТЕЗ-ын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

### **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### **Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа:**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

### **Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д. Цэцэгмаа үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, Б.Азбаяр нар 2018 оны 09 дүгээр сарын 17-ний өдрөөс эхэлж, 2018 оны 10 дугаар сарын 29-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

### **Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам**

Аудитын тайлан нь үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмжтэй байхаас гадна холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар бичлээ.

Аудитын тайлангийн төслийг дарга, тэргүүлэх аудиторын зөвшөөрснөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, тайлангийн эцсийн хувилбарыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, ҮАГ-ын САГ, аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**Үндсэн мэдээлэл**

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн № 8/03 тоот тогтоолоор аймгийн 2018 оны төсвийг дараахь байдлаар баталсан байна.

№	Орлого зарлагын төрөл	Дүн /сая.төг/
<b>1</b>	<b>Аймгийн ТЭЗ-ийн нийт орлогын эх үүсвэр</b>	<b>67742,9</b>
	Аймгийн 2018 оны төсөвт төвлөрүүлэх орлого	9482.5
	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	14363.2
	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	3795.7
	Аймгийн төсөвт Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	39966.3
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого	135.2
<b>2</b>	<b>Аймгийн 2018 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээ</b>	<b>67742,9</b>
	Аймгийн ИТХ	570.8
	Аймгийн Засаг даргын харьяаны байгууллага	67172.2
	Сумдад	44501.1
	Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	5816.6
	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	1541.4
	Аймгийн төсвөөс 2018 оны төсвийн жилд сумдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	37143.1
	Баянхонгор аймаг	22671.1
	Аймгийн ЗДТГ	1599.5
	Аймгийн Засаг даргын Ерөнхий данс	2531.7
	Санхүүгийн хяналт аудитын алба	114.0
	Орон нутгийн өмчийн газар	132.2
	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	638.0
	Сум дундын ойн анги	46.5
	Ахмад настны асрамжийн газар	98.4
	Халамжийн сан	7969.9
	Хот тохижилт-Үйлчилгээ ОНӨГазар	383.5
	Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба	56.7
	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	5232.2
	Орон нутгийн хөрөнгө оруулалт	910.0
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	2958.4

Аймгийн төсвийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт /барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж/-ын зардлын хэмжээг 6605,2 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 20 сумдын татварын орлогоор нийт 2190.8 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1.2 сая төгрөгоруулахаар баталжээ.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн судалгаагаар 13 сумын сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос 1652.1 сая төгрөгийг бүрдүүлэхээр баталжээ. Харин Гурванбулаг, Баянговь, Баянбулаг, Баян-Овоо, Жинст, Заг, Бууцагаан зэрэг сумдууд сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг батлаагүй байгаа нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.б-д заасны дагуу сумын ИТХ-аас сум хөгжүүлэх сангийн төсвийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” журмын 3.3.1-т “...сумын ИТХ ...сум хөгжүүлэх сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд, олгох зээлийн хэмжээг тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн эхний хагас жилийн татварын гүйцэтгэлийн мэдээгээр цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 227.8 сая, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар 53.1 сая төгрөгөөр тус тус тасарч, үл хөдлөх эд хөрөнгийн татвар 49.4 сая, газрын төлбөр 34.0 сая, улсын тэмдэгтийн хураамж 34,2 сая, орон нутгийн зам ашигласны хураамж 53,4, ус ашигласны төлбөр 21.5 сая төгрөгөөр давжээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн орлогыг төлөвлөхдөө уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс орох орлогыг өмнөх оны гүйцэтгэлд суурилж, тооцоо судалгаагүйгээр 400,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь үндэслэл муутайгаас 2018 оны ТЕЗ-ийн орлогын төлөвлөгөө тасрахаар байна.

Төсөвт байгууллагууд төсвийн гүйцэтгэлийн тайланд зарим зардлыг буруу тайлагнасан, орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэлийг оруулаагүй, дутуу оруулсан зэргээс шалтгаалж ТЕЗ-ийн 2018 оны 2 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдсэн байна.


Аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийг хэрэгжүүлэгч байгууллагаар гаргуулалгүй, төсвийн мэргэжилтэн гаргаснаас биелэлтийг тооцоход хүндрэлтэй байв.

## АУДИТЫН ДҮН

### БҮЛЭГ 1.


Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн орлогыг төлөвлөхдөө уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс орох орлогыг өмнөх оны гүйцэтгэлд суурилж, тооцоо судалгаагүйгээр 400,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь үндэслэл муутай байна.

1.1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдснаар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 14363,2 сая, тусгай зориулалтын шилжүүлэгээр 39966,3 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 3795,7 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 135,2 сая төгрөгийг хуваариалсан бөгөөд



аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04 ний өдрийн № 8/03 тоот тогтоолоор Татварын болон татварын бус орлогыг 9482,5 сая төгрөгөөр тооцож, нийт 67742,9 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулахаар төсөв батлагдсан байна. /График-1/

Мөн 20 сумдын татварын болон татварын бус орлогоор нийт 2257.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн орон нутгийн төсөвт байгууллагыг санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд аймгийн ТЕЗ-ийн нийт орлого 70000.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.



Тусгай шилжүүлгээр эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 5673,9 сая, ерөнхий боловсролын үйлчилгээнд 21199,6 сая, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 9495,0 сая, газрын харилцаа кадастрын үйлчилгээнд 402,1 сая, соёлын үйлчилгээнд 2360,4 сая, нийтийн биеийн тамирт



507,2 сая, хүүхэд хөгжил хамгаалалын үйлчилгээнд 328,2 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна. /График-2/


2018 онд аймгийн ТЕЗ-ийн дүнгээр татварын орлогыг 8667,9 сая төгрөгөөр төвлөрүүлэхээр тооцсон бөгөөд татварын орлогын нэр төрөл дараах байдалтай байна.

Хүснэгт №1 /сая.төг/					
№	Татварын орлогын төрөл	Аймгийн Татварын хэлтсийн нэггэсэн татварын дүн	Хувь	Сумдын тогтоолыг нэггэсэн дүн	зөрүү
<b>А</b>	<b>Б.Нийт орон нутгийн төсөв</b>	<b>8,777.8</b>	<b>100.0</b>	<b>8,667.9</b>	<b>110.0</b>
1	В. Аймгийн нэгдсэн төсөв /712/	5,207.4	59.3	5,207.4	-
1.1	ЦХТА орлого /Суутган-1/	5,050.0	57.5	5,050.0	-
1.2	ХХОАТ-ын буцаан олголт	(800.0)	(9.1)	(800.0)	-
1.3	АТӨЯХ-н татвар	433.0	4.9	433.0	-
1.4	ҮХЭХ-ийн татвар	200.4	2.3	200.4	-
1.5	Газрын төлбөр	324.0	3.7	324.0	-
<b>Б</b>	<b>Г.Орон нутгийн төсөв</b>	<b>3,569.8</b>	<b>40.7</b>	<b>3,460.5</b>	<b>109.4</b>
2	Хүн амын орлого	1,227.0	14.0	1,208.0	19.0
2.1	ИОТТХ	451.5	5.1	432.5	19.0
2.2	Хадгаламжийн хүү	650.0	7.4	650.0	-
2.3	ҮХЭХ борлуулсны	80.0	0.9	80.0	-
2.4	Бууны татвар	45.5	0.5	45.5	-
3	бусад төлбөр хураамж	1,521.8	17.3	1,432.5	89.4
3.1	Улсын тэмдэгтийн хураамж	237.1	2.7	237.1	-
3.2	Орон нутгийн зам ашигласны	147.8	1.7	147.8	-
3.3	Хог хаягдлын хураамж	308.5	3.5	300.0	8.5
3.4	Ус ашигласны төлбөр	400.0	4.6	400.0	-
3.5	Түгээмэл тархацтай АМАТ	12.0	0.1	9.0	3.0
3.6	Агнуурын нөөц ашигласны	408.0	4.6	331.0	77.0
3.7	Нохой	8.5	0.1	7.6	0.9
4	Хүү торгууль	821.0	9.4	820.0	1.0

Аудитаар аймгийн Татварын хэлтсийн нэгтгэсэн татварын орлогын төлөвлөгөөг сумдын төсөв баталсан тогтоолуудтай тулган шалгахад нийт дүнгээр 110.0 сая төгрөгийн төсвийн орлогын төлөвлөгөөг дутуу нэгтгэсэн байна. /Хүснэгт №1/

*Тухайлбал: ИОТТХ болон хадгаламжийн хүүгийн орлогыг нийт дүнгээр 19.0 сая төгрөгөөр илүү, хог хаягдлын хураамжыг Бууцагаан сумын 6.0 сая, Галуут суманд 2.5 сая нийт 8.5 сая төгрөгөөр дутуу, түгээмэл тархацтай ашигт малтмалын Баацагаан сумын 0.5 сая, Галуут сумын 2.5 сая төгрөгийн татварыг дутуу, ан агнуурын нөөц ашигласан төлбөр Баян-Овоо сумын 53.0 сая төгрөгийг нэгтгээгүй, Баацагаан сумын 7.1 сая, Галуут сумын 16.5 сая төгрөгийн дутуу нэгтгэсэн, нохойны татварыг нийт дүнгээр 0.9 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн байна.*

Иймд дээрх зөрүүтэй нэгтгэсэн төлөвлөгөөг дахин хянаж зөрчлийг арилгахыг аймгийн Засаг дарга болон аймгийн Татварын хэлтсийн даргад зөвлөв.



Аймгийн татварын бус орлогоор нийт 2830,0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд: Жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн эргэн төлөлтөөр 100,0 сая, ТБОНӨ-д бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 550,0 сая, хандив тусламжийн орлогоор 2180,0 сая төгрөг төлөвлөсөн байна.

Баянхонгор аймагт уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс 2017 оны гүйцэтгэлээр 1780.0 сая төгрөг хандив орсонд суурилж, тус орлогыг үндэслэлгүйгээр 400,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2180,0 сая төгрөгөөр төлөвлөснөөс төлөвлөгөө тасарч, аймгийн ОНХС-аас санхүүжих зарим төлөвлөсөн ажлууд хэрэгжих боломжгүй байдалтай байна.

Харин ТБОНӨ-д бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг хэрхэн төлөвлөсөн талаар тодруулахад “шламны орлогоос 250.0 сая төгрөг, “Кроунд Гео” ХХК-аас 250.0 сая төгрөгийг оруулна гэж Засаг даргын зөвлөлийн хурлаар нэмсэн, харин 50.0 сая төгрөг нь орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого орно гэж төлөвлөн аймгийн Орон нутгийн өмчийн газрын төвлөрүүлэх орлогод баталсан гэсэн тайлбарыг СТСХ-ийн орон нутаг хариуцсан мэргэжилтэн өгөв.

Аймгийн ТЕЗ-чийн дүнгээр нийт 71833,4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд төсөл хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр ангилан авч үзвэл:

Хүснэгт №2		
№	Зарлагын төрөл	Дүн /сая.төг/
1	ТЕЗ-ийн тусгай шилжүүлгийн байгууллага	40101.5
2	Аймгийн төвийн орон нутгийн 9 төсөвт байгууллагад	3639.6
3	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд	5232.2
4	Сумдад олгох ОНХС-ийн шилжүүлгээр	1541.4
5	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар	910.0
6	Халамжийн санд	7969.9
7	Ангилалдаагүй зардлаар	2531.7
8	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	5816.6
9	Сумдын төсвийн орлогоор сумдын төсөвт байгууллагуудад	2257.7
10	Сумдын сум хөгжүүлэх сан	1385.3
11	Сумдын төлөвлөсөн татварын бус орлого	447,5
<b>ТЕЗ-ийн нийт зардал</b>		<b>71883,4</b>

Хөрөнгө оруулалтын шинж чанартай барилга байгууламж, зураг төсөв шаардагдах төсөл арга хэмжээг батлахдаа зураг төсөвт магадлал хийгээгүй төсөл арга хэмжээг баталж Төсвийн тухай хуулийн 29.4<sup>1</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

1.2. Аймгийн ТЭЗ нь нийт орлого, зарлагыг 71833,4 сая төгрөгөөр баталж, Төсвийн тухай хуулийн 57.2<sup>2</sup> дахь заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

**БҮЛЭГ 2.**

**Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн орлогын төлөвлөгөө бүрэн биелэх боломжгүй байна.**

2.1. Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн 2018 оны 3 дугаар улирлын татварын орлогын мэдээнд тулгуурлан аймгийн ТЭЗ-ийн орон нутгийн татварын орлогын урьдчилсан гүйцэтгэлийг гаргав.

Аймгийн орон нутгийн төсөвт 2018 оны эхний 3 улирлын байдлаар татварын орлогоор нийт 7231,6 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7016,3 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 97,0 хувиар буюу 215,3 сая төгрөгөөр тасалсан байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

/сая төг/

Татварын орлогын төрөл	Жилийн төлөвлөгөө	3-р улирлын төлөвлөгөө	3-р улирлын гүйцэтгэл	Хувь
<b>Б.Нийт орон нутгийн төсөв</b>	<b>8,667,8</b>	<b>7,231,6</b>	<b>7,016,2</b>	<b>97.02</b>
<b>В. Аймгийн нэгдсэн төсөв</b>	<b>5,207,4</b>	<b>4,524,0</b>	<b>4,067,7</b>	<b>89.91</b>
ЦХТА орлого /Суутган-1/	5,050,0	3,667,5	3,186,7	86.89
ХХОАТ-ын буцаан олголт	(800,0)			
АТӨЯХ-н татвар	433,0	433,0	399,1	92.17
ҮХЭХ-ийн татвар	200,4	145,0	186,7	128.73
Газрын төлбөр	324,0	278,5	295,3	106.02
<b>Г.Орон нутгийн төсөв</b>	<b>3,460,5</b>	<b>2,707,6</b>	<b>2,948,6</b>	<b>108.90</b>
<b>Хүн амын орлого</b>	<b>1,208,0</b>	<b>897,3</b>	<b>1,145,0</b>	<b>127.61</b>
ИОТТХ	432,5	315,2	332,9	105.60
Хадгаламжийн хүү	650,0	485,6	702,9	144.77
ҮХЭХ борлуулсны	80,0	60,0	84,2	140.38
Бууны татвар	45,5	36,5	25,0	68.38
<b>Бусад төлбөр хураамж</b>	<b>1,432,5</b>	<b>1,209,2</b>	<b>1,116,7</b>	<b>92.35</b>
Улсын тэмдэгтийн хураамж	237,1	169,5	203,9	120.31
Орон нутгийн зам ашигласны хураамж	147,8	147,8	182,6	123.55
Хог хаягдлын хураамж	300,0	225,0	228,3	101.49
Ус ашигласны төлбөр	400,0	340,0	144,5	42.50
Түгээмэл тархацтай АМАТ	9,000	9,000	5,719	63.54
Агнуурын нөөц ашигласны	331,0	310,3	346,6	111.68
Нохой	7,6	7,6	5,1	67.03
Хүү торгууль	820,0	601,1	686,9	114.27

<sup>1</sup>Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>2</sup>Орон нутгийн төсвийг алдаадалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

Татварын бус орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 2018 оны ТЕЗ-ийн орлогын төлөвлөгөө тасрахаар байна.

Татварын бус орлого	Төлөвлөгөө	/сая төг/	
		Гүйцэтгэл	Хувь
ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого	100.0	10.4	10.36
ТБОНӨ-д бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	550.0	33.3	6.05
Хандив тусламжийн орлого	2180.0	207.0	9.50
<b>ДҮН</b>	<b>2830.0</b>	<b>250.7</b>	<b>8.86</b>

2017 оны 12 сарын 31-ны байдлаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийн 501,2 сая төгрөгийг аймгийн ТЕЗ-ийн тайланд авлагаар бүртгэсэн бөгөөд 2018 онд зээлийн эргэн төлөлтөөс 100,0 сая төгрөг эргэн төлөгдөхөөр төлөвлөсөн байна. Тухайн зээлүүд хугацаа хэтэрсний улмаас хууль хяналтын байгууллагад шилжүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа боловч 2018 оны 10 дугаар сарын байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 10,3 сая төгрөг төлөгдөж, тус орлогоос орох орлого тасрахаар байна. Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээлийг олгох зорилгоор “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийг байгуулсан байна. Иймд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон зээлийн төлөгдөөгүй үлдэгдлийг тооцож, тус компанид шилжүүлж, барагдуулах арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын болон нөхөн сэргээлтийн аж, ахуйн нэгжүүдээс хандив тусламжийн орлогоор нийт 2180,0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 207,0 сая төгрөг төвлөрсөн байна. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Ажил сайжруулах тухай” 0112809 тоот албан бичгээр нөхөн сэргээлтийн аж ахуйн нэгжүүдээс хандив авахыг таслан зогсоох чиглэл өгсөн тул тус хандивын орлого тасарч, зөвхөн уул уурхайн ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгжүүдээс дээрхи орлого орсон байна.

Хөрөнгө борлуулсны орлогоор 550.0 сая төгрөг оруулахаар баталжээ. Үүнээс аймгийн Орон нутгийн өмчийн газарт төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөөгөөр 50.0 сая, шламны орлогоос 250,0 сая,

орон нутгийн өмчийн оролцоот “Корунд Гео” ХХК-аас 250.0 сая төгрөгийг оруулахаар баталжээ.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой дээрх 500,0 сая төгрөг орох боломжгүй гэсэн тайлбарыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн өгөв.

Харин ОНӨГ-ын хөрөнгө борлуулсаны орлогоор өгсөн төлөвлөгөөний 33.3 сая төгрөг буюу 66.6 хувь нь гүйцэтгэлээр орсон ба ондоо багтаан орлого бүрэн биелэх боломжтой байна.

2.2. Аймгийн ТЕЗ-ийн хүрээнд төлөвлөсөн орлогод дүн шинжилгээ хийхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогыг цаашид нэмэгдүүлэх бололцоотой гэж үзэж байна.

2018 оны улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй барилгуудын төсөвт тусгагдсан түгээмэл тархацтай ашигт малтмалын хэмжээг барилгын төсвөөс түүвэрлэж үзэхэд дараах тооцоолол гарав.

Аймгийн төвд баригдаж байгаа барилгуудын хувьд түгээмэл тархацтай ашигт малтмалыг ихэнхдээ Өлзийт, Баян-Овоо сумдын газар нутгаас олборлодог бөгөөд барилгын төсвөөс түүвэрлэсэн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг Өлзийт сумын 2013 онд тогтоосон тарифаар тооцов.

Хөрөнгө	Хэмжих нэгж	Элс	Тариф	Дүн	Хайрга	/сая төг/		
						Тариф	Дүн	
УТХО-ын хөрөнгөөр эрх шилжиж баригдаж буй барилгаас	м.куб	10819.5	5000	54097.5	7589.1	22500	170754.8	
ОНХС-аар хийгдэж байгаа барилгаас	м.куб	3799	5000	18995.0	1912.3	22500	43026.8	
<b>ДҮН</b>		<b>14618.5</b>		<b>73092.5</b>	<b>9501.4</b>		<b>213781.5</b>	
<b>Зөвхөн УТХО-аас эрх шилжсэн болон ОНХС-д батлагдсан ТАХ-ээр</b>								<b>286874.0</b>

Дээрх хүснэгтээс харахад түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогоос 286,9 сая төгрөгийн орлого орох бололцоотой байгаа боловч хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнийн техник эдийн засгийн үндэслэл, төсвийг тооцохдоо тухайн барилгад шаардагдах элс хайрганы хэмжээг тооцож оруулсан боловч нэгж өртөг тавиагүйгээс үнэгүй тооцсон байгаа нь тухайн төрлийн татварыг тооцож төсөв бүрдүүлэх бололцоогүй байна. Иймд цаашид барилга байгууламжийн төслийг

боловсруулахад түгээмэл тархацтай ашигт малтмалын татварыг төсөвт нь суулгаж холбогдох хуулийн дагуу татварын орлогыг тооцож төсөв бүрдүүлэх талаар нэмэлт судалгааг хийж, оны эцэст орлого нэмэгдүүлэх санал оруулахаар шийдвэрлэв.

2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний төсөвт суугдсан түгээмэл тархацтай ашигт малтмалын өртгийн судалгааг дараах байдлаар харуулав.

/ сая төг/

Д/д	ТАХ	Хэмжих нэгж	Уулын элс			Голын элс			Хайрга		
			хэмжээ	үнэ	Нийт	хэмжээ	үнэ	Нийт	хэмжээ	үнэ	Нийт
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Өлзийт сум/	М.куб	200	0	0.0			0	161.9		0.0
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	М.куб	416	0	0.0			0	1602.9		0.0
3	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын засвар Баянхонгор	М.куб	6.3	0	0.0			0	0.7		0.0
4	Дотуур байрын барилга /Баянхонгор, Жинст сум/	М.куб	388.5	1100	0.4	587.8	1100	0.64658	1105.1	1200	1.3
5	Цэцэрлэгийн барилгын дуусгал /Баянхонгор, Баянхонгор сум/	М.куб	99.9	10000	1.0			0	616.9	1400	0.9
6	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Баянхонгор, Баянхонгор сум/	М.куб		0	0.0			0			0.0
7	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, Баянговь сум/	М.куб			0.0			0			0.0
8	Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар /Баянхонгор,	М.куб	49.2	0	0.0	266	0	0	280.9	0	0.0
		М.куб	116.2	0	0.0	147.4	0	0	182.4	0	0.0
9	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Богд сум/	М.куб	748.9	0	0.0	1353	0	0	1615.9	0	0.0
10	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Жинст сум/	М.куб	745.2	0	0.0	814.6	0	0	1348.1	0	0.0
11	Ахуйн үйлчилгээний төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	М.куб	308.6	22000	6.8	114.66	25000	2.8665	487.2	113400	55.2
12	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Жаргалант сум/	М.куб	42.3	0	0.0	29.1	0	0	28.7	0	0.0
13	Сургуулийн спорт заалын барилга /Баянхонгор, Баянхонгор сум, Эрдэнэмандал ахлах сургууль/	М.куб	148.8	0	0.0	134.5	0	0	135.3	0	0.0
14	Цэцэрлэгийн барилгын дээвэр засвар /Баянхонгор, Галуут сум/	М.куб	30.2	0	0.0	15	0	0	23.1	0	0.0
	Өлийт сумын тогтоосон тарифаар тооцоход		3300.1	5000	8.2	3462.06	26100	3.51308	7589.1	116000	57.4

Дээрх судалгаанаас харахад хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын үнийг ихэнхдээ үнэгүй тооцож байгаа нь энэ төрлийн татвар бүрдэхэд бэрхшээлтэй гол асуудал болж байна.

Цаашид улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт төдийгүй хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга, байгууламжаас тухайн төрлийн татварыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Мөн хадгаламжийн хүүгийн орлогыг сумд дунджаар 10.0-20.0 сая төгрөгөөр тооцсон байхад Баянговь, Баянлиг, Жинст сум тус орлогыг төлөвлөөгүй байгаа нь дээрх сумдад тухайн төрлийн татварын орлогыг нэмж бүрдүүлэх боломжтой байхаар байна. Хадгаламжийн хүүгийн орлого нь аймгийн хэмжээнд 2018 оны эхний 9 сарын байдлаар 485,6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 702,9 сая төгрөг буюу 144,8 хувийн биелэлттэй гарчээ.

Энэхүү орлогыг аймгийн нэгдсэн макро үзүүлэлт гараагүй учраас 2019 оны орон нутгийн төсөв батлахад орлого нэмэгдүүлэх, зарлага хорогдуулах саналд тусгахаар шийдэв.

### **БҮЛЭГ 3.**

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 оны 2 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаагүй байна.

3.1. Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлээр 42119.1 сая төгрөгийн санхүүжих эх үүсвэр батлагдснаас гүйцэтгэлээр 39295.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Санхүүжилтийн дутуу эх үүсвэр нь тусгай зориулалтын шилжүүлэгээс 27,9 сая, орон нутгийн төсвөөс 788,3 сая, туслах үйл ажиллагааны орлого буюу хандив тусламжийн орлого 2154,2 сая төгрөгөөр тасарч, үндсэн үйл ажиллагааны орлого 668.1 сая төгрөгөөр давсан үзүүлэлттэй гарчээ.

Төсвийн Fiscal программд эрүүл мэндийн төсвийн мэргэжилтнээс бусад төсвийн мэргэжилтнүүд байгууллагуудын батлагдсан орон тоог оруулаагүй, зарим төсвийн байгууллага орон тооны гүйцэтгэлийг мэдээлээгүй ба төсвийн гүйцэтгэлийн тайланд дараахь алдаа илэрлээ.Үүнд:

- *Жинст сумын ОНХС-ийн зарлага орлогоосоо 11,9 сая төгрөгөөр давсан;*
- *Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн зарлага орлогоосоо 3,3 сая төгрөгөөр давсан;*
- *Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг 13 сум оруулаагүй байна. Энэ нь сумдууд Төсвийн тухай хуульд заасан хугацаанд СХС-ийн төлөвлөгөөг баталж, аймгийн СТСХ-т ирүүлээгүй, СХС-ийн төлөвлөгөөг дараа нь Сангийн яамнаас өөрчилсөнтэй холбоотой байна. Төсөвт тодотгол хийхгүй байх албан бичгийн дагуу СХС-ийн төлөвлөгөөнд тодотгол хийгдээгүй ба 2018 оны 09 дүгээр сард тодотгол хийхийг зөвшөөрсний дагуу төлөвлөгөөг программд оруулсан байна.*

- *Өлзийт сум СХС-ийн орлогын гүйцэтгэлийг мэдээлээгүй.*
- *Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт байгууллагуудын батлагдсан орон тоог оруулаагүй, Биеийн тамир спортын газар орон тооны гүйцэтгэлийг буруу мэдээлсэн, Богд, Жаргалант сумдын байгууллагууд орон тооны гүйцэтгэлийг мэдээлээгүй.*
- *Зарим байгууллагууд жирэмсэн амаржсаны тэтгэмжийн мөнгийг санхүүгийн тайланд нийгмийн даатгалаас санхүүжих орлогоор тайлагнасан.*
- *Орон нутгийн музей халаалтын зардлын төлөвлөгөөг буруу мэдээлсэн.*

Сумдын соёлын төвүүдэд өөрийн орлогоор жил бүр 2,0 сая төгрөг оруулахаар төлөвлөдөг бөгөөд 2018 онд Баянговь, Эрдэнэцогт зэрэг 5 сумын соёлын төвүүдийн байгууллагын орлогын төлөвлөгөөг сүүлийн хагас жилд тавьсан байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

2018 оны 2 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарим зардлын гүйцэтгэлийг харьцуулан судалж үзэхэд дараахь байдалтай байна. Үүнд:

Цалингийн зардлыг аймгийн ТЕЗ-ийн дүнгээр эхний хагас жилд 16493,9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 15948,6 сая төгрөгийг зарцуулж, зардлыг 545,4 сая төгрөгөөр хэмнэсэн бөгөөд үүнийг хөтөлбөрөөр нь авч үзвэл сумдын ЭМТ-үүд 32,3 сая, соёлын төвүүд 11,7 сая, ИТХ-ууд 15,8 сая, ЗДТГ-ууд 91,4 сая, цэцэрлэгүүд 223,9 сая, ЕБС-ууд 132,9 сая, аймгийн төвийн байгууллагууд 37,4 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Цалингийн зардлын хэмнэлтийн шалтгааныг тодруулан шалгахад зарим ажиллагсдын ээлжийн амралтын нөхөн олговрыг олгоогүй, жирэмсний амралттай байсан хүний оронд ажилтан аваагүй, ажлыг хавсран гүйцэтгүүлсэн, 2 дугаар улирлын үр дүнг олгоогүй, цэцэрлэгүүд нүүдлийн бүлэг ажиллаагүй байсан зэрэгтэй холбоотой байна.

ТЕЗ-ийн 2018 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар хоолны зардал 202,1 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Хоолны зардлыг ЕБС-уудын дүнгээр 82,3 сая, цэцэрлэгүүдийн дүнгээр 110,0 сая, ЭМТ-үүдийн дүнгээр 9,5 сая, ИТХ-ын дүнгээр 2,6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Оны эхэнд хүнсний материалын үлдэгдэлтэй байсан, хүүхдийн ирцийн гүйцэтгэлээр зардлыг олгосон зэргээс шалтгаалж, хоолны зардал хэмнэгдсэн байна.



Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цайны зардлыг 2018 оны эхний хагас жилд 453,4 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 377,5 сая төгрөг зарцуулж, зардлыг 75,9 сая төгрөг хэмнэсэн ба зардлын хэмнэлт нь үдийн цайг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр олгосонтой холбоотой байна.

Халаалтын зардлыг аймгийн дүнгээр эхний хагас жилд 143,7 сая төгрөгөөр хэмнэсэн бөгөөд үүнээс сумдын ЗДТГ-ууд 14,8 сая, ЕБС-ууд 38,0 сая, цэцэрлэгүүд 16,3 сая, соёлын төвүүд 9,2 сая, ЭМТ-үүд 28,6 сая, аймгийн төвийн байгууллагууд 36,8 сая төгрөгөөр халаалтын зардлыг хэмнэсэн байна. Аймгийн төвийн байгууллагуудаас Биеийн тамир спортын хороо зардлыг 11,1 сая, Орон нутгийн музей 4,2 сая, аймгийн ЗДТГ 8,7 сая, ХДТ 11,9 сая төгрөгийн зардал хэмнэсэн байна. Үүний шалтгааныг тодруулахад аймгийн Хөгжимт драмын театр 9 дүгээр сарын 15-наас эхлэх халаалтын зардал хэмнэгдсэн, аймгийн ЗДТГ түрээсийн зардлаас халаалтын зардлыг төлсөнтэй холбоотой байна. Харин Орон нутгийн музей нь оны эхэнд нүүрсний үлдэгдэлтэй байсан, Биеийн тамир спортын газрын цэвэр бохир усны зардлыг халаалтын зардалтай андуурч гүйлгээ хийсэнтэй холбоотой байна.

Өмнөх онд нүүрсний үлдэгдэлтэй байсан, Номундалай цогцолбор сургууль, Эрдэнэцогт, Заг сумын сургуулиуд өмнөх оны өглөгийг шилжүүлээгүйгээс халаалтын зардал хэмнэгдсэн байна.

Хөрөнгийн зардалд 5971,7 сая төгрөг батлагдсанаас эхний хагас жилд 2196,0 сая төгрөг зарцуулж, 3775,7 сая төгрөг хэмнэгджээ. Тус хэмнэлтийн 619,9 сая төгрөг нь ОНХС-тай, 3155,8 сая төгрөг нь аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын тендер зарлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер хагас жилээс хойш явагдсантай холбоотой байна.

2018 оны 04 дүгээр сард “Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэл”-д Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраа саудит хийж, “Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төсвийн мэргэжилтнүүд аймгийн төсвийн орлого, зарлага болон салбарын үзүүлэлт, төсвийн гүйцэтгэлийн тайланд шинжилгээ хийж, тайлбар тодруулга гарган, орлого нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг сайжруулах талаар судалгаа гарган, аймгийн бодлого шийдвэрт тусгуулж байх” гэсэн зөвлөмжийг аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга нарт хүргүүлсэн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

**Тухайлбал: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг шилэн дансанд байршуулахдаа зөвхөн тоон үзүүлэлтээр гаргаж, түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг дэлгэрэнгүйгээр байршуулаагүй, аймгийн ТЕЗ-ийн дүнгээр эхний хагас жилийн орлого, зардалд дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.**

Аймгийн СТСХ-ээс 2017 оноос хойш төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн тайланд 3 дугаар улирлын байдлаар дүн шинжилгээ хийж, зардлын хэтрэлт, хэмнэлтийг тодруулж, төсөвт зохицуулалт хийж иржээ. Зардлын хэмнэлтээс сумдын ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны зөөлөн эдлэлийг шинэчилж, сүүлийн үеийн тоног төхөөрөмжтэй боловч 380 кВ-д холбогдоогүйгээс галлагаатай сумдыг 380 вт-д холбож өгсөн байна.

Орон нутгийн байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн төлөвлөлтийг аймгийн СТСХ-ийн 2 мэргэжилтэн хариуцаж, эрүүл мэндийн салбарын төлөвлөлтийг аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн хариуцаж ажиллаж байна. Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн судалгаа СТСХ-д байхгүй байгаа бөгөөд цаашид эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэнг аймгийн СТСХ-т ажиллуулж, аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийг ахлах мэргэжилтэн гаргаж, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.2. Аймгийн ОНӨГ оны эхний 9 сард 28951,9 сая төгрөгийн 126 худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 26613,1 сая төгрөгийн байгуулж, 2255,8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарчээ. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны тендерээс 1749,3 сая, урсгал зардлын худалдан авах ажиллагааны тендерээс 61,1 сая, орон нутгийн хөгжлийн сангийн худалдан авах ажиллагааны тендерээс 412,1 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны тендерээс 33,3 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Улирлын шинж чанартай зарим ажлуудыг төсөв батлагдсан даруйд эхлүүлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.8<sup>3</sup> дах заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7.б<sup>4</sup>-д заасныг мөрдөж, тодорхой улиралд гүйцэтгэх,

<sup>3</sup>“Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх”

<sup>4</sup>“улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг улирлын шинж чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлсэн байх.”

онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй оны эхний улиралд багтаан гэрээ байгуулж ажлууд чанаргүй хийгдэх, хугацаандаа ажил дуусахгүй байдалд хүргэж болзошгүй байна.

Тухайлбал: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын барилга, Баян-Ойт сургуулийн барилга, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Баянговь сумын цэцэрлэгийн барилгын өртөтгөл, Баянхонгор сумын ахуйн үйлчилгээний барилга, Богд, Жинст сумын Соёлын төвийн барилга, Баянхонгор сумын хуримын ордонь барилга, Баянхонгор сумын 5,6 дугаар багийн өрхийн эмнэлгийн барилга, Баянхонгор сумын 2.3 дугаар багийн гэр хороололд спортын талбай, цэцэрлэгт хүрээлэн барих зэрэг ажлуудын худалдан авах ажиллагааг 2018 оны эхний улиралд багтаан зохион байгуулаагүй байна.

ТБОНӨХБАУХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.1<sup>5</sup> дэх заалт, Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа урамшууллыг зохицуулах журам”-ын 2.1<sup>6</sup>, 2.3<sup>7</sup>-д заасны дагуу 2018 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд тендерийн үнэлгээний хороог байгуулж, аймгийн Засаг даргын захирамжаар баталсан байна.

ТБОНӨХБАУХАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5<sup>8</sup> дахь заалтын дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанд тендерийг зохион байгуулж, шилэн дансны нэгдсэн систем болон Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд мэдээллийг байршуулж иржээ.

Засгийн газрын 2015 оны 24 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.4<sup>9</sup> дэх заалтыг зөрчсөн 3 гүйлгээ хийсэн байна.

*Тухайлбал: Аймгийн Засаг даргын захирамж гараагүй байхад 2018 оны 01 дүгээр сарын 19-нд аварга малчны цом, шагналын үнэнд 8,5 сая, 2018 оны 02 дугаар сарын 22-*

<sup>5</sup>“Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөгт өгнөх хуулийн 8.1.1-д заасанд эдэх язгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна”

<sup>6</sup>“Үнэлгээний хорооны гишүүд нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Үнэлгээний хороог захиалагчийн шийдвэрээр байгуулна”

<sup>7</sup>“Үнэлгээний хороо нь сондгой тооны гишүүдтэй байна”

<sup>8</sup>“Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна”

<sup>9</sup>“Өрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана”

ны өдөр нутгийн зөвлөлийн золголтод 11,5 сая, 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр мөсний баярт оролцох зардалд 1,5 сая төгрөгийг тус тус олгосон байна.

#### БҮЛЭГ 4.

Аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо болон чанарын үзүүлэлтийг байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн боловсруулаагүй байна.

4.1. Төсвийн тухай хуулийн 22.6.5<sup>10</sup>-д заасны дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит VIII хуралдааны 8/03 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар аймгийн ТЕЗ-д хамаарах 13 байгууллага, салбарын 2018 онд хэрэгжүүлэх 41 хөтөлбөрт 59 арга хэмжээний хүрэх үр дүнг баталсан байна. Харин Орон нутгийн музей, Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүжин театр, Биеийн тамир спортын газар, Хот тохижилт үйлчилгээ ОНӨГ, Гадаад харилцаа, аялал, жуулчлалын алба зэрэг байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тодорхойлж батлаагүй байна.

Дээрх байгууллага, салбар тус бүрийн тухайн жилд хүрэх арга хэмжээний тоо болон чанарын үзүүлэлтийг тодорхойлохдоо тухайн байгууллагуудаас төсвийн төсөлтэй хамт гаргуулж аваагүй, жил бүр аймгийн СТСХ-ийн мэргэжилтэн гаргаж ирсэн байна.

Байгууллагуудын хөтөлбөрийн үр дүнгийн хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг хэрхэн тодорхойлж гаргасан нь ойлгомжгүй, өмнөх 2017 оны үзүүлэлттэй ижил хийсэн байгаа нь түүний үр дүнг тооцож гаргахад хүндрэлтэй, бодит байдалтай нийцэхгүй байна.

Аудитын явцад хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлтийг байгууллагуудаар гаргуулахад Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2018 оны хөтөлбөрийн тоон болон чанарын үзүүлэлтийг 2016-2017 онд хэрэгжиж дууссан хөтөлбөрийн хүрээнд гаргасан тул биелэлт гаргаж ирүүлэх боломжгүй гэсэн албан бичиг ирүүлсэн, харин аймгийн ЗДТГ биелэлтийг гаргаж ирүүлээгүй болно.

Жилийн эцэст байгууллагуудаас тухайн төсвийн жилд гүйцэтгэсэн ажлын тоо, чанарын үзүүлэлтийн тайланг шилэн дансны нэгдсэн санд Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн

<sup>10</sup>“төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах”.

агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.1.1<sup>11</sup>-т заасны дагуу 2017 оны жилийн эцсийн тайланг байршуулаагүй, 2018 оны төлөвлөгөөг байршуулахдаа хугацаа хоцроосон, мэдээллийг эмх цэгцгүй байршуулснаас мэдээлэлтэй танилцахад хүндрэлтэй, хэвлэж авах боломжгүй байлаа. Иймд цаашид мэдээллийг ойлгомжтой, тогтсон хугацаанд мэдээлж байх шаардлагатай байна.

Аймгийн Засаг дарга яамдуудтай хамтран ажиллах гэрээг оны дараа 1,2 дугаар сард байгуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1<sup>12</sup> дэх заалтыг зөрчсөн байна. Аймгийн ИТХ-ын хуралдаанаар аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнг баталсаны дараа аймгийн ТЕЗ яамдуудтай гэрээ байгуулж байгаагаас зарим байгууллагын хөтөлбөрийн үр дүн аймгийн ИТХ-аар батлагдаагүй орхигдсон байна.

Тухайлбал: БСШУС-ын сайдтай 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр байгуулсан гэрээний 2 дугаар хавсралтаар батлагдсан хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны хэрэгжилт, 3 дугаар хавсралтаар батлагдсан Номын сангийн фондын баяжилт хийх чиглэлээр зохион байгуулсан ажлын хэрэгжилт, 4 дүгээр хавсралтаар батлагдсан театр, чуулга, аймгийн Нийтийн номын сан, музей, 5 дугаар хавсралтаар батлагдсан биеийн тамирын спортын талаар авах арга хэмжээний талаар хийж хэрэгжүүлэх ажил аймгийн ТЕЗ-ийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, үр дүнд тусгагдаагүй байна.

Улсын төсөв батлагдсанаас хойш 14 хоногийн дараа аймгийн Засаг дарга яамдуудтай гэрээ байгуулж, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтыг хэрэгжүүлж, тус гэрээг үндэслэн аймгийн төсөв батлагдахад салбар тус бүрийн хөтөлбөр, хүрэх үр дүнг аймгийн ИТХ-д өргөн барих шаардлагатай байна. Иймд улсын төсөв батлагдсанаас хойш яамдууд ТЕЗ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1<sup>13</sup> дэх заалтыг хэрэгжүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулах саналыг ҮАГ-аар дамжуулан ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

<sup>11</sup>“ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 04 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлнэ”;

<sup>12</sup>“Энэ хуулийн 14.1.6, 14.1.8-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.”;

<sup>13</sup>“Энэ хуулийн 14.1.6, 14.1.8-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.”;

Цаашид төсвийн гүйцэтгэлийн тайланг тухайн жилд хийж хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний төсөв, хүрсэн үр дүнг тусгасан гүйцэтгэлийн хамт тусгаж, бодлогын зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах арга зүйгээр төсөвт байгууллагуудыг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

4.2. Аймгийн ТЭЗ-тай гэрээ байгуулсан төсвийн захирагчид аймгийн ИТХ-аас баталсан хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсвийг зарцуулж байгаа боловч зарим хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхдээ холбогдох хууль, дүрэм журам зөрчиж байна. Тухайлбал:

Нийтийн тээврийн алдагдалд олгох татаасаар 36,0 сая төгрөг баталсан байна. Тус арга хэмжээг нийтийн тээврийн үйлчилгээ явуулдаг “Төгс төгөлдөр үйлс” ХХК гүйцэтгэж байгаа боловч аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, төсвөөс 2018 оны 1-8 дугаар сард нийт 18,0 сая төгрөг олгосон байхад тус аж ахуйн нэгжид хяналт тавьж ажиллаагүй байна. Иймд тус аж ахуйн нэгжид өгөх санхүүжилтийг зогсоож, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсаны дараа ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлээр санхүүжилт олгож байхыг зөвлөв.

Мөн Баянхонгор суманд өрхийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа “Оточномгон” өрхийн эмнэлэг аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй байхад санхүүжилт олгосон байна.

Ангилалдаагүй зардлаас аймгийн ИТХ-аар баталж орон нутгийн өмчит “Баянхонгор нью майнинг” ХХК-д үйл ажиллагааны зардалд 26,0 сая, “Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д 65,0 сая төгрөгийн санхүүжилт олгосныг 2017 оны ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар цаашид төсвөөс дэмжлэг олгохыг зогсоох зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд 2018 онд аймгийн Засаг даргатай эдгээр компаниуд ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй байна.

Иймд цаашид дээрх компаниудыг үйл ажиллагааны орлогоор зардлаа нөхөж ажиллах зарчимд шилжүүлж, төсвөөс санхүүжилт өгөхийг зогсоох зөвлөмжийг хүргүүлэв.

Аймгийн ТЭЗ-ийн хүрээнд гадаад албан томилолтын зардалд 61,0 сая төгрөг зарцуулсан байхад томилолтоор ажилласан ажлын тайланг тайлагнах ажил хангалтгүй байна. Тухайлбал:

Аймгийн ИТХ-ын 2018 оны төсөвт 60,0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр эхний 9 сард 31,9 сая төгрөгийг олгосон атлаа томилолтоор ажилласан тайланг ирүүлээгүй байхад түүнийг санхүүгийн тайланд зардлаар бүртгэсэн байна.

Мөн ангилагдаагүй зардлын бүлгээс гадаад томилолтын зардалд 30,0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр эхний 9 сард 29,1 сая төгрөг олгосон байхад холбогдох анхан шатны баримтыг томилолтоор ажилласан тайлангийн хамт ирүүлээгүй байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 , 13.7 заалтууд, Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 12 -т заасныг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аймгийн ЗДТГ-ын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг тулган шалгахад 2018 оны эхний 6 сард 228,9 сая төгрөг зарцуулжээ. Засаг даргын нөөц хөрөнгийн 35,7 хувийг шагнал, уралдаан тэмцээний зардалд, 8,9 хувийг зочин төлөөлөгч хүлээн авах зардалд, 10,3 хувийг сургалт, зөвлөгөөн зохион байгуулах зардалд, 28,7 хувийг бусад зардалд, 11,1 хувийг гамшгаас хамгаалах зардалд зарцуулж, 5,3 хувийг иргэдэд буцалтгүй тусламж хэлбэрээр олгожээ.

Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1<sup>14</sup>-т заасны дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэлгүй аймгийн Засаг дарга захирамж гаргасан байна. Энэ талаар аймгийн Засаг даргатай ярилцлага хийхэд “Иргэдээс өргөдөл гомдол ирсэн үед яаралтай шийдвэрлэх байдал үүсдэг бөгөөд Засаг даргын зөвлөлийг хуралдуулах цаг хугацааны боломж гардаггүй. Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэх журмын энэ заалтыг өөрчлөх саналыг удаа дараа хэлж, санал өгсөн” гэсэн тайлбарыг өглөө.

Аудитад хамрагдсан хугацаанд нөөц хөрөнгөөс 13,9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулах шийдвэр гаргахдаа Сангийн сайдын 2012 оны 239 тоот журмын 2 дах заалтыг үндэслэлгүй шийдвэр гаргасан бөгөөд үлдэх 215,0 сая төгрөгийг зарцуулах шийдвэрт журмын 2.1.3<sup>15</sup> -т заасан заалтыг мөрдсөн байна. Гэтэл малын шүлхий

<sup>14</sup>“Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна.

<sup>15</sup>“Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх”.

өвчинтэй холбоотой нийт 32,2 сая төгрөг зарцуулахдаа журмын 2.1.1<sup>16</sup> -т заасныг үндэслэхээр байхад шийдвэр гаргахдаа 2.1.3 дахь заалтыг баримталсан байна.

Иймд цаашид Засаг даргын нөөц хөрөнгөөс гарах зардлыг журмын 3.1-т заасны дагуу Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу зарцуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад 17881,1 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг бүрдүүлээгүй зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.7 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.5 дах заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор 2017 онд байгуулагдсан “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ, “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААТҮГ-ууд ТУЗ байгуулаагүй, аудитын явцад шаардсан мэдээллийг ирүүлээгүй болно.

4.3. Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс Баянхонгораймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлд эхний хагас жилийн байдлаар дүгнэж, биелэлтийг 49,68 хувьтай гаргажээ. 2018 онд аймгийн ТЕЗ-ийн хэмжээнд нийт 251 арга хэмжээг 2018 онд авч хэрэгжүүлэхээс 33 ажлыг үр дүнтэй буюу 90-100%, 75 ажлыг тодорхой үр дүнд хүрсэн буюу 60-89 хувь, 98 ажлыг эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-59 хувь гэж үнэлж, 45 ажлыг үр дүнгүй гэж үнэлжээ.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлаас 45 ажлыг 0-30 хувийн биелэлттэй гаргаснаас хэрэгжих хугацаа болоогүй ажил 27, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүйгээс хэрэгжээгүй ажил 9, явц удаашралтай ажил 5, хэрэгжээгүй ажил 4 байна гэж дүгнэжээ.

Харин аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс байгууллагуудад хяналт хийхдээ аймгийн ИТХ-аар баталсан хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, биелэлтийг тооцдоггүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5<sup>17</sup> -тай нийцэхгүй байгаад цаашид

<sup>16</sup>Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;

<sup>17</sup>Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэж, дотоод аудит хийнэ”



анхаарч ТШЗ нар жилийн эцэст хүрэх үр дүнг тоон болон чанарын үзүүлэлтээр гаргаж, хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгааныг гаргаж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитаар нийт 74,9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага өгөв.

---

*54.5.1. тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/;*

*54.5.2. татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт;*

*54.5.3. тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;*

*54.5.4. хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;*


*54.5.5. нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга;*

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн орлогыг төлөвлөхдөө уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс орох орлогыг өмнөх оны гүйцэтгэлд суурилж, тооцоо судалгаагүйгээр 400,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь үндэслэл муутай байна.
2. Сумдын татварын орлогын төлөвлөгөөг аймгийн Татварын хэлтэс зөрүүтэй нэгтгэсэн байна.
3. Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн орлогын төлөвлөгөө бүрэн биелэх боломжгүй байна.
4. Аймгийн Засаг дарга ТЕЗ нартай хамтран ажиллах гэрээг Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан хугацаанд байгуулаагүй байна.
5. Төсвийн байгууллагууд орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, орон тоог зөв тайлагнаагүйгээс аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны 2 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй байна.
6. Аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо болон чанарын үзүүлэлтийг байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн боловсруулаагүй байна.
7. Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дах заалтыг хэрэгжүүлж аймгийн ИТХ-аар баталсан хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс хяналт тавиагүй байна.
8. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.8 дах заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7.б-д заасныг мөрдөөгүйгээс улирлын шинж чанартай ажлууд чанаргүй хийгдэх, хугацаандаа ажил дуусахгүй байдалд хүргэж болзошгүй байна.
9. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа холбогдох журмыг мөрдөж ажиллаагүй байна.

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЦЭЦЭГМАА



## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### Нэг. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа:

1. Аймгийн ИТХ-аар батлагдсан 2018 оны төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтыг хэрэгжүүлж, хуульд заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагч нартай гэрээ байгуулах.
3. Төсвийн шууд захирагчдаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тоон болон чанарын үзүүлэлтээр гаргуулж, аймгийн ИТХ-д өргөн барьж, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дах заалтыг хэрэгжүүлж хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.
4. Засаг даргын нөөц хөрөнгөөс гарах зардлыг журмын 3.1-т заасны дагуу Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу зарцуулж байх.
5. Улирлын шинж чанартай ажлуудыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.8 дах заалт, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7.б-д заасныг мөрдөж оны эхний улиралд багтаан гэрээ байгуулж ажиллах.
6. Орон нутгийн өмчит ХХК-иудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааны орлогоор зардлаа нөхөж ажиллах зарчимд шилжүүлж, төсвөөс санхүүжилт өгөхийг зогсоох.
7. Сумдын татварын орлогыг зөрүүтэй нэгтгэсэн төлөвлөгөөг дахин хянаж зөрчлийг арилгаж, цаашид орлого, зарлагын гүйцэтгэлд хяналт тавьж, дүн шинжилгээ хийж ажиллах.

### Хоёр. Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэн танаа:

1. Аймгийн ЗДТГ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тайлан, биелэлтийг гаргах ажил үүргийн хуваарийг холбогдох мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод тусгаж биелэлтэд хяналт тавьж ажиллах.

### Гурав. Аймгийн Татварын хэлтсийн дарга С.Рэнцэндагва танаа

1. Сумдын татварын орлогыг зөрүүтэй нэгтгэсэн төлөвлөгөөг дахин хянаж зөрчлийг арилгах.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЦЭЦЭГМАА





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 38

Номгон

Аудитын тайланг баталгаажуулах тухай


Монгол Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 тоот тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 1.1, 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Б.Должмаа/-д үүрэг болгосугай.

Гурав. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Должмаа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /Д.Цэцэгмаа/-д тус тус даалгасугай.

ДАРГА  Б. МӨНХБАТ

2518018

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГАА

Аймгийн нэр: Баянхонгор

/сая.төг/

№	Үзүүлэлт	Сангийн ямны хянасан дүн	2018 он			
			Анх батлагдсан	Тодотгол- 1	Тодотгол- 2	Тодотгол- 3
А	Б	1	2	3	4	5
	<b>ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар</b>		2017 оны 12 сарын 04-ны өдрийн 8/03			
	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО</b>					
	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	65,547.7	71,228.7			
	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	7,324.2	12,418.2			
	Татварын орлого	6,613.5	7,840.3			
	Татварын бус орлого	710.7	4,578.0			
	<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>		550.0			
	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	58,223.5	58,260.5			
	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>					
	БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО					
	ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО					
	ӨМНӨХ ОНЫ ҮНДСЭН ТЭНЦЛИЙН АШИГ /өмнөх оны давсан орлогоос, хэмнэгдсэн зардлаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс/					
	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА</b>					
	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	65,547.7	71,833.4			
	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	58,599.4	64,565.5			
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,628.6	50,037.1			
	ХҮҮ	-	-			
	ТАТААС	499.3	485.9			
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,471.5	14,042.4			
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	6,948.3	7,267.9			
	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>		-			
	<b>УРСГАЛ ТЭНЦЭЛ</b>	(51,275.2)	(52,147.3)			
	<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	0.0	(604.7)			
	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		604.7			
	<b>1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт</b>					
	<b>2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих</b>		604.7			
	<b>3. Бусад</b>					

2018 онд төсөвт тодотгол хийгдээгүй байна.

Бэлтгэсэн: Ахлах аудитор


Аудитор

Хянасан: Аудитын менежер

Б.Должмаа

Б.Азбаяр

Д.Цэцэгмаа



## Орон нутгийн төсвийн орлогын судалгаа

Аймгийн нэр: Баянхонгор

/сая.төг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2018 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Урьдчилсан гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=4-2
	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	65925.8	71833.4		68048.1	-3785.3
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	11388.5	12968.2		9787.6	-3180.6
<b>А</b>	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	10984.6	12418.2		9287.6	-3130.6
1	Татварын орлого	8196.7	7840.3		8075.6	235.4
1.1	Орлогын албан татвар	5601.6	5412.5		5814.3	401.8
1.1.1	Хувь хүний орлогын албан татвар	6373.0	6212.5		6465.0	252.5
1.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-771.4	-800.0		-650.7	149.3
1.2	Өмчийн татвар	297.4	245.9		280.3	34.4
1.3	Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	399.7	433.0		425.0	-8.0
1.3.1	Тусгай зориулалтын орлого	0.0			0.0	0.0
1.3.2	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	399.7	433.0		425.0	-8.0
1.4	Бусад татвар /гөлбөр хураамж/	1898.0	1748.9		1556.0	-192.9
2	Татварын бус орлого	2787.9	4578.0		1212.0	-3366.0
<b>Б</b>	<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	403.9	550.0		500.0	-50.0
Б-1	Хөрөнгө борлуулсны орлого	403.9	550.0		500.0	-50.0
<b>В</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	53206.8	58260.5		58260.5	0.0
В-1	ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2163.3	3795.7		3795.7	0.0
В-2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	12251.4	14363.2		14363.2	0.0
В-3	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	38651.3	39966.3		39966.3	0.0
В-4	ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	140.8	135.2		135.2	0.0
В-5	Бусад тусламж					0.0
<b>Г</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	1330.5	604.7			-604.7
Г-1	БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО					0.0
Г-2	ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО					0.0
Г-3	ӨМНӨХ ОНЫ ҮНДСЭН ТЭНЦЛИЙН АШИГ /өмнөх оны давсан орлогоос, хэмнэгдсэн зардлаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс/	1330.5	604.7			-604.7

Тайлбар: Төсөвт тодотгол хийгээгүй тул 5 дугаар мөрний томъёог анх батлагдсан төсөв мөр болгож өөрчилсөн.

Бэлтгэсэн: Ахлах аудитор


Аудитор

Хянасан: Аудитын менежер

Б.Должмаа

Б.Азбаяр

Д.Цэцэгмаа



## Баянхонгор аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан /дэлгэрэнгүй/

Дээд шатны байгууллага: Засгийн газар

/сая.төг/

ТГ-ийн тайлан-гийн Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2018 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Урьдчилсан гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=4-2
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>67,343.39</b>	<b>71833.4</b>	<b>-</b>	<b>67,407.7</b>	<b>(4,425.7)</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>62768.685</b>	<b>64565.5</b>	<b>0</b>	<b>62,514.7</b>	<b>(2,050.8)</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>49597.407</b>	<b>50037.1</b>	<b>0</b>	<b>49,356.5</b>	<b>(680.7)</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	28506.9	28705.9		29,557.7	851.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	3153.29	3464.9		3,543.0	78.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал					
		5217.47	6774.3		6,568.8	(205.6)
2104	Хангамж, бараа материалын зардал	1323.4	1168.0		1,163.5	(4.5)
2105	Нормативт зардал	2944.96	3253.5		2,769.3	(484.2)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1019.69	405.1		350.2	(54.9)
2107	Томилголт, зочны зардал	263.377	330.1		278.4	(51.7)
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1878.77</b>	<b>1877.4</b>	<b>0</b>	<b>1,699.2</b>	<b>(178.3)</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1843.3	1803.6		1,635.8	(167.8)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4.4	2.9		2.3	(0.6)
210803	Даатгалын үйлчилгээ	18.9	14.7		12.7	(2.0)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4.19	3.8		2.7	(1.1)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1.3	1.7		1.0	(0.8)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2.28	45.7		41.7	(4.0)
210807	Газрын төлбөр	1.5	1.1		0.3	(0.7)
210808	Банк, СБ-ын үйлчилгээний хураамж	2.3	3.9		2.5	(1.4)
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.6	0.0			-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5289.55</b>	<b>4057.9</b>	<b>0</b>	<b>3,426.4</b>	<b>(631.5)</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4820.58	3374.2		2,851.2	(523.0)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	468.97	683.6		575.2	(108.5)
211	<b>ХҮҮ</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр		0.0			-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		0.0			-
212	<b>ТАТААС</b>	<b>421.5</b>	<b>485.9</b>	<b>0</b>	<b>431.1</b>	<b>(54.9)</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		0.0			-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	421.5	485.9		431.1	(54.9)
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12749.778</b>	<b>14042.4</b>	<b>0</b>	<b>12,727.2</b>	<b>(1,315.2)</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>441.668</b>	<b>2309.8</b>	<b>0</b>	<b>2,163.4</b>	<b>(146.4)</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	441.668	2309.8		2,163.4	(146.4)
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		0.0			-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12308.11</b>	<b>11732.6</b>	<b>0</b>	<b>10,563.8</b>	<b>(1,168.8)</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1081.56	646.0		646.0	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6649	7264.0		7,264.0	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	70.9	591.4		460.5	(130.9)
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1095.2	881.1		790.8	(90.4)
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		0.0			-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэвэр	742.7	584.8		584.8	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан АХ-дад төрөөс үзүүлэх дэмжлэг	1498.7	744.4		737.7	(6.7)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1170.05	1020.8		80.0	(940.8)
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4574.7</b>	<b>7267.9</b>	<b>0</b>	<b>4,892.9</b>	<b>(2,375.0)</b>
220001	Барилга байгууламж	2839.4	5232.2		3,173.5	(2,058.6)
221001	Их засвар	0	0.0			-
222001	Тоног төхөөрөмж		0.0			-
223001	Бусад хөрөнгө	1735.3	2035.7		1,719.4	(316.3)
224001	Стратегийн нөөц хөрөнгө		0.0			-
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭ</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>
230001	Эргэж төлөгдөх зээл		0.0			-
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		0.0			-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		0.0			-



ТГ-ийн тайлан- гийн Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2018 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Урьдчилсан гүйцэтгэл	Зөрүү
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>67423.29</b>	<b>71833.4</b>	<b>0</b>	<b>70,333.4</b>	<b>(1,500.0)</b>
	Улсын төсвөөс санхүүжих	38613.8	39967.3		39,967.3	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24349.5	27548.2		27,048.2	(500.0)
	НДС-ийн төсвөөс санхүүжих		0.0			-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	4459.99	4317.9		3,317.9	(1,000.0)
	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих					-
	Бусад эх үүсвэр					-
	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>153</b>	<b>157.0</b>	<b>0</b>	<b>157.0</b>	<b>-</b>
	Төсвийн байгууллага	153	157.0		157.0	-
	Төсвөөс гадуур байгууллага					-
	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>3667</b>	<b>3632.0</b>	<b>0</b>	<b>3,623.0</b>	<b>(9.0)</b>
	Удирдах ажилтан	295	310.0		310.0	-
	Гүйцэтгэх ажилтан	2180	2122.0		2,124.0	2.0
	Үйлчлэх ажилтан	936	936.0		903.0	(33.0)
	Гэрээт ажилтан	256	264.0		286.0	22.0
	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО ( жилийн дунджаар )</b>	<b>20831</b>	<b>22995.0</b>	<b>0</b>	<b>21,980.0</b>	<b>(1,015.0)</b>
	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	15892	17778.0	0	16,804.0	(974.0)
	Төрийн өмчит ЕБС	15892	17778.0		16,804.0	(974.0)
	Хувийн өмчит ЕБС					-
	<b>Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад</b>	<b>4939</b>	<b>5217.0</b>	<b>0</b>	<b>5,176.0</b>	<b>(41.0)</b>
	Төрийн өмчит СӨБ байгууллагад	4939	5217.0		5,176.0	(41.0)
	Хувийн өмчит СӨБ байгууллагад					-

Тайлбар: Төсөвт тодотгол хийгээгүй тул 5 дугаар мөрний томъёог анх батлагдсан төсөв мөр болгож өөрчилсөн.

Бэлтгэсэн: Ахлах аудитор


Б.Должмаа

Аудитор

Б.Азбаяр

Хянасан: Аудитын менежер

Д.Цэцэгмаа



## Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн 2018 оны орон тоо, цалингийн сангийн судалгаа

Дээд шатны байгууллага: Засгийн газар

/сая.төг/

№	Байгууллагын нэр	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил				Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл				Ажиллагсдын тоо						Тайлбар	
		Өмнөх оны гүйцэтгэл	2018 оны			Өмнөх оны гүйцэтгэл	2018 оны			Өмнөх оны гүйцэтгэл	2018 оны		Үүнээс:				
			Төсөө	Гүйцэтгэл	Зөрүү		Төсөө	Гүйцэтгэл	Зөрүү		Төсөө	Гүйцэтгэл	Удирдах	Гүйцэтгэх	Үйлчлэх		Гэрээт
А	Б	1	2	3	4=3-2	5	6	7	8=7-6	9	10	11	12	13	14	15	16
1	Орон нутгийн төсвийн байгууллага	28506.9	28705.89	29557.66	851.77	3153.3	3464.866	3542.994	78.13	3667	3632	3623	310	2124	903	286	
ДҮН		28506.9	28705.89	29557.66	851.77	3153.3	3464.866	3542.994	78.13	3667	3632	3623	310	2124	903	286	

Бэлтгэсэн: Ахлах аудитор


Аудитор

Хянасан: Аудитын менежер

Б.Должмаа

Б.Азбаяр

Д.Цэцэгмаа



## Гадаад албан томилолтын зардлын судалгаа

Аймгийн нэр: Баянхонгор

№	Өмнөх оны гадаад томилолтын гүйцэтгэл /сая.төг/	2018 он			Тайлбар
		Гадаад томилолтоор ажилласан хүний тоо	Томилолтын төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	
1	19.2	37.0	91.0	61.0	Аймгийн ИТХ 60.0 сая, ангилагдаагүй зардал 30.0 сая, Богд сумын ИТХ 1.0 сая төгрөгөөр төлөвлөсөн.
2					
<b>Дүн</b>			91		

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Б.Должмаа

Аудитор

Б.Азбаяр

Хянасан: Аудитын менежер

Д.Цэцэгмаа



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2018 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ  
ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО  
ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн нэр: Баянхонгор

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2018 оны зорилтот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
1	1.1 Хурлын ажлын залгамж чанарыг хангах, хурлын төлөөлөгчид, Тэргүүлэгчид, нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан, сонгуультад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	130		156.9	156.9	Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдээс 2018 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.02.21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталжээ. Аймгийн ИТХ-ын хуралдаан 2018 онд 4 удаа хуралдаж, 17 тогтоол, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлож, 6 хороогоор чиглэлийн дагуу хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас 2018.06.27-ны өдөр ажлын хэрэгжилтийг хагас жилээр гаргаж, УИХ-ын Тамгын газар, Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагаас хамтран хэрэгжүүлж буй "Монгол улс дахь төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь" төслөөс аймгийн ИТХ-тай хамтран "Тэргүүлэгчдийн манлайлагч" сургалтыг 2018 оны 04 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд, сумдын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн "Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлагч" сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Шаргалжуут рашаан сувиллыг түшиглэн зохион байгуулсан байна. Хангайн бүсийн аймгуудын ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны албан хаагчдын "Хангайн бус-2018" зөвлөгөөнийг Өвөрхангай аймгийн ИТХ-аас 2018 оны 09 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд Хужирт сумд зохион байгуулж, төлөөлөгчид, ажлын албаны ажилтнууд оролцсон байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 47 дугаар тогтоолоор баталсан "Сумдын ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу сумдын ИТХ-ын ажлыг дүгнэж, байр зэлүүлсэн байна.
2	1.2 НӨУБ-ын үйл ажиллагааг иргэд сонгогчидод ил тод нээлттэй болгож хурал, Тэргүүлэгчдээс гарах шийдвэрт тэдний саналыг аач тусгаж байх	696		320.8	320.8	Аймгийн ИТХ-ын дарга Хангайн сумдад 2018.07.19-2018.08.16-ний өдрүүдэд ажиллаж, иргэд, олон нийтэд хууль болон орон нутгийн хурал, захиргааны байгууллагаас зохиож байгаа ажлын талаар мэдээлэл хийжээ. Аймгийн хэмжээнд бүх сум, багуудад "Бэлчээрийн менежментийг сайжруулах нь" хэлэлцүүлгийг зохион байгуулж, аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гарсан байна. "Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж, шаардлагатай ажил зохион байгуулах" хэлэлцүүлгийг 2018.10.10-ны өдөр зохион байгуулжээ.
3	Аймгийн ИТХ 1.3 Аймгийн ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах	375		90.0	90.0	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын жилийн төлөвлөгөөг 4 бүлэг 41 ажилтай баталж, ГХУСА-ын талаархи төрийн бодлого, хууль, эрх зүйн акт, тогтоол шийдвэрийг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хуулиа дээдэлб" аяныг зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 1100 сурагчид "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт, 1250 төрийн албан хаагчдад Зөрчлийн тухай хуулиар, "Бага насны хүүхдийн хүчирхийлээс ангид байх орчинг дэмжих нь" сургалтыг аймгийн төвийн 10 дугаар цэцэрлэг, Богд сумын цэцэрлэг дээр зохион байгуулан хүүхэд, эцэг, эх, багш, ажилчдыг хамруулжээ. Сумдын зохицуулах зөвлөлийн ажлын тайланг хагас, бүтэн жилээр нэгтгэн, тусгай журмын дагуу шалгаж байр зэлүүлэн зөвлөлийн хуралд танилцуулан, шалнал урамшууллыг олгожээ. Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих зорилгоор "LEAD MONGOLIA" хөтөлбөрийн Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бэлтгэл хэрэгжүүлсэн "Transparent and Accessible Hospital" төслийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна.Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнд өртөж хохиорохоос урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах ажилд сурагчдын эцэг, эхчүүдийг татан оролцуулж, үүрэг гүйцэтгэх "School police" эргүүл тогтмол ажиллаж иржээ. Бага насны хүүхдийн хүчирхийлээс ангид байх орчинг дэмжих нь сургалтыг зохион байгуулах, түгээн дэлгэрүүлэхэд "Хонгорын үр сад" төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.
4	1.4 Цагаатгах ажлыг зохион байгуулах комиссын ажлыг зохион байгуулах	30		2.9	2.9	"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуульд 2018.01.12-ны өдөр орсон зарим өөрчлөлтүүдийн дагуу материалаа бүрдүүлсэн 14 иргэний материалыг Талчуулын ерөнхий газрын тусгай архиваас шүүлтэн холбогдох материалыг аач Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлээд байна. Мөн сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт дээрх "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуульд 2018.01.12-ны өдөр орсон зарим өөрчлөлтүүдийг сурталчилах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөсөн албан тоот, сумдаас ирүүлсэн материалын бүрдлийг хангах талаар зөвлөмжүүдийг тус тус хүргэж ажиллалаа. Тайланг хугацаанд "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуульд 2018.01.12-ны өдөр зарим өөрчлөлтүүд орсонтой холбогдуулан 23 иргэн тодруулга, зөвлөгөө авахаар аймгийн ИТХ-д хандаж тодорхой мэдээллүүдийг авчээ.

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнийн үзүүлэлт		2018 оны зорилгот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, тахилдуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
5	1.5	Цагаатгах ажлыг зохион байгуулах комиссын ажлыг зохион байгуулах	20				Баянхонгор аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос 2018 оны 1, 2, 3 дугаар улиралд зохион байгуулсан ажлын тайланг хүргүүлж, дүгнүүлэн ажиллажээ.	
6	Аймгийн ЗДТГ	2.1	Захиргааны удирдлага, зохицуулалт	Төрийн захиргааны стандарт хэрэгжсэнээр	923.6			
7		2.2	Хууль арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх	Захирамж тогтоол хянах төлөвлөгөөт 350 захиалгат 122 зайны 150 сургалтыг 2-оос доошгүй удаа явуулсан байна	82.2			
8		2.3	Хүний нөөцийн удирдлага, сургалт, хөгжлийн төлөвлөлт, арга зүйгээр хангах	Төрийн албаны зөвлөлийн тогтоол, заавар, журмын заалт хэрэгжсэн байх	95.1			
9		2.4	Сум, агентлаг байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шилжилтгээ хийх, үнэлгээ дүгнэлт гаргах, зөвлөгөө зөвлөмж өгөх	20 сумд жилд 2 удаа, хэлтэс агентлагаар улиралд 1 удаа явж ажил байдалтай тахилцана	241.2			
10		2.5	Зөвсг даргын хуулиар олгогдсон бүрэн эрхсээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шилжтэй, урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зарим зардал			257.4		
11	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	3.1	Аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг хууль, журмын дагуу ил тод шуурхай, үр ашигтай явуулахад мэргэжилтэн ажилтнуудад мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	Аймаг, 20 суманд	Аймгийн 20 сум, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд	71.2	71.2	Аймгийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг хууль, журмын дагуу ил тод шуурхай, үр ашигтай явуулах зорилгоор захиалагч, тендэрт оролцогч 20 гаруй аж ахуйн нэгжүүдийн холбогдох хүмүүст ахлах мэргэжилтэн Б.Цэрэнлхагва сургалт явуулж, тендэрт хэрхэн оролцох, төлөвлөгөөгө шивих тоон гарын үсэг авах, материалаа хэрхэн илгээх талаар арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллажээ. 2018 оны ТЕЗ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан бүх худалдан авах ажиллагаа 100% цахимгаар явуулсан байна.
12		3.2	Худалдан авах үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгжүүдэд ил тод нээлттэй болгох	Аймаг, 20 суманд	100 хувь			Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2018 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг үндэсний өдөр тутмын "Монголын үнэн" сонинд оны эхэнд нийтлүүлж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон Баянхонгор аймгийн албан ёсны <a href="http://www.bayankhongor.gov.mn">www.bayankhongor.gov.mn</a> сайтуудад сар бүрийн зарласан болон зарлагдах тендерийн урилгыг байршуулан олон нийтэд сурталчилж, шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг тухай бүр оруулж иржээ.

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2018 оны зорилгот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
13		3.3	Орон нутгийн өмчийн бүртгэл	Орон нутгийн өмчит 208 байгууллагын хөрөнгөтэй холбоотой асуудлыг өмчийн албаар дамжуулан шийдвэрлүүлдэг болгосон байна.	150	57.1	57.1	Өмч хөрөнгө шинээр олж авах, шилжүүлэх ахлах, худалдах, зээмшигч тогтоох талаар орон нутгийн өмчит 150 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 38 тогтоол, өмч хөрөнгөтэй холбоотой 4 журам гаргуулж биелэлтийг тооцон ажиллаж байна. Орон нутгийн өмчит 62 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 38 тогтоол гаргуулж, 80 байгууллагын хүсэлтийг албан тоотоор хүргүүлсэн бөгөөд одоогоор 8 байгууллагын хүсэлт хүлээгдэж байна. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор орон нутгийн өмчит 88 байгууллагын 7.4 тэрбум төгрөгийн хөрөнгөд зээмшигч тогтоож, орон нутгийн өмчит 28 байгууллагын 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгөд дансны залруулга хийлгэж, орон нутгийн өмчит 18 байгууллагын 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг ахталсан байна. Мөн орон нутгийн өмчит 18 байгууллагын 899,5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, 15 байгууллагын 66,4 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж, ХХААГ-ын хөрөнгийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид тус тус шилжүүлсэн байна. Дуудлагын худалдааны орлогоор 50.0 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 38,2 сая төгрөгийг аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Өмчийн мэргэжилтэнүүд хөдөө орон нутагт ажиллаж мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.
14		3.4	Орон нутгийн өмчийн бүртгэл	Орон нутгийн өмчит 208 байгууллагын шинээр бий болсон хөрөнгүүдийг цахим санд бүртгэлжүүлснээр хөрөнгө алдагдах, бүртгэлд тусгагдахгүй оржигдох явдал 100 хувь арилж хяналтанд орно.	197	3.7	3.7	Орон нутгийн өмчит 197 байгууллагын үндсэн хөрөнгийг 2014 оноос эхлэн "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулж жил бүр хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг хийж байна. Уг программд хөрөнгө шаж оруулсан байдлаар 2018 оны 3 дугаар сард мониторинг үнэлгээ хийхэд аймгийн хэмжээнд 67,75 хувьтай байгаа нь хангалтгүй гэж үзээд ТӨБЭЗГ-ын программын мэргэжилтэн Лхагвасүрэнг урьж 2018.10.03-ны өдөр бүх нягтлан бодогч нарт сургалт зохион байгуулсан байна.
15		3.5	Орон нутгийн өмчтэй холбоотой гэрээ, эрхийн хэрэгжилтийн талаар	Орон нутгийн өмчит 208 байгууллагын өмч эзэмшлийн гэрээг дүгнэж "А" үнэлгээтэй дүгнэгдсэн 2 байгууллагын дарга, нягтлан бодогчийг урамшуулах	197	0.2	0.0	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 42 дугаар тогтоолоор "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх, гэрээ байгуулах, дүгнэх журам, гэрээний загварын батлуулж Орон нутгийн өмчит 197 байгууллагатай өмч эзэмшлийн гэрээг байгуулж дууссан. Гэрээг дүгнээгүй байна. 2018 оны төсөвт урамшууллын зардал тусгагдаагүй байна.
16	Сум дундын Ойн анги	4.1	Ойн нөөц баялгыг хамгаалах, нөхөн сэргээх үржүүлэх, нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх	20000 ширхэг навчит модны үр суулгах, ойн сан бүхий сумдад ойн менежментийг хэрэгжүүлэн Эрдэнэцогт, Галуут, Жаргалант, Баянбулаг сумдад, Зөгийн ойг Богд, Баянлиг, Жинст Баацагаан хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн ажиллана. Ойн цэвэрлэгээг ойн бүсүүдэд хийх.	Айл өрх, албан байгууллагууд ногоон бүс бий болгож эрүүл цэвэр агаарт ая тухтай амьдрах	46.5	46.5	Мод үржүүлгийн газарт 40000 ширхэг модны үр, үрсэлгээ бэлдэн тариалж байна. Эрдэнэцогт, Галуут, Жаргалант, Богд, Баянлиг, Жинст, Баацагаан зэрэг ойн сан бүхий сумдад ойг хамгаалах, хууль бус модны зөрчил гарах зэргээс урьдчилан сэргийлж, ард иргэдэд холбогдох хууль тогтоомжийг сурталчлан байгаль хамгаалагч нартай хамтран ажиллахаар төлөвлөсөн боловч ажиллах хүчний нөөц, санхүүгийн боломж муутгайгаас тухайн ажил хийгдээгүй байна. Ойн сан бүхий газруудаар яаж айл өрхүүдэд гал түймрээс урьдчилан сэргийлэх, хортон шавьжаас хамгаалах, яриа танилцуулга зөвлөмж өгч, холбогдох хууль тогтоомжийг сурталчилан ажиллаж иржээ.

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2018 оны зорилгот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
17	Халамжийн сан	5.1	Нийгмийн халамж, үйлчилгээ	31463	20594	7,969.8	7,969.8	1996 иргэнд 2.539,5 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 1732 иргэнд 900,0 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, 1767 иргэнд 647,3 сая төгрөгийн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжийг үзүүлжээ. Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлт тусламжаар 3385 иргэнд 260,2 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт тусламжаар 409 иргэнд 100,9 сая төгрөг олгосон байна. Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжид 2180 иргэнд 316,4 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээнд 8630 иргэн хамруулж 852,6 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 355 иргэнийг хамруулж 50,1 сая төгрөгийг олгожээ. Амьжиргааг дэмжих зөвлөлийн 140 гишүүдэд 15,7 сая төгрөгийн урамшуулал олгож, үйл ажиллагааны зардал 2,1 сая төгрөгийг олгосон байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг сар бүрийн 20-ны дотор иргэдэд чирэгдэлгүй олгосон байна.
18	Асрамжийн газар	6.1	Асрамжийн үйлчилгээ	10	10	98.4	98.4	Ахмад настны асрамж үйлчилгээний төв нь харж хандах хүнгүй нийт 10 өндөр настанд асрамжийн үйлчилгээг хүргэн, эхний 9 сарын байдлаар цалингийн зардалд 39,5 сая хоолны зардалд 10,0 сая, хангамжийн зардалд 1,2 сая, тогтмол зардалд 8,2 сая төгрөгийг зарцуулсан байна.
19	Аймгийн Ахмадын хороо	7.1	Төрийн бодлого шийдвэрийг ахмад настуудад хүргэх	20	18	75.2	75.2	"Ахмад настны тухай" хуулийн 14-р зүйл, "Ахмадаа ачлала" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 20 сумын Засаг дарга, 20 сумын ИТХ-ын дарга, тэргүүлэгчид нийтдээ 160 удирдах ажилтанд "Төрөөс Ахмадын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, аймаг, орон нутгийн удирдлагын дэмжлэг, оролцоо" сэдэвт сургалт зохион байгуулжээ. 20 сумын Ахмадын хорооны дарга, аймгийн төвийн томоохон байгууллагуудын дэргэдэх Ахмадын зөвлөлийн дарга, мэргэжлийн Ахмадын холбоодын дарга нарт "Ахмад настны хууль"-ийг хэрэгжүүлэх талаар Монголын Ахмадын холбооноос зохион байгуулсан сургалт семинарын агуулга, ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн танилцуулга, ахмад настны мэдээллийн санг үүсгэх, ашиглах, баяжуулах, мэдээлэх арга зүйн талаар сургалт зохион байгуулсан байна. Ахмадын ордонд өдөр бүр тодорхой хөтөлбөрт арга хэмжээнүүд зохион байгуулагдаж хэвшжээ. Даваа гаригт ахмадын зөвлөх үйлчилгээ, Мягмар гаригт Идэвхтэн сонгуультны чадваржуулах сургалт арга зүйн өдөр, Лхагва гаригт Өв соёл түүх уламжлалын өдөр, Пүрэв гаригт Спорт эрүүл мэндийн арга хэмжээ, Баасан гаригт Цаг үе ажил төрлийн мэдээлэлийн ажлууд явагддаг, өдөр бүр цэнгээнт бүжиг, чөлөөт хөтөлбөрт арга хэмжээнүүд явагдаж байна. Геронтологийн үндэсний төвтэй хамтран сум дундын эмнэлэг, сумдын багийн эмч нар, өрхийн эрүүл мэндийн төв, ахмад настан хариуцсан эмч мэргэжилтнүүдэд "Геронтологи-гериатрийн үндсэн ойлголт, орчин үеийн чиг хандлага", "Дэлхий дахины насжилтын чиг хандлага ба эрүүл насжилт" сэдвээр сургалт зохион байгуулжээ. Хангайн бүсийн сумдын Ахмадуудын чуулга уулзалт 7-р сард Буулцагач суманд болж, 8 сумын ахмадууд чуулж урлаг спортын тэмцээн явуулж, ахмадын байгууллагынхаа ажил туршлагаа солилцсон бөгөөд говийн бүсийн сумдын чуулга уулзалт 8-р сард Өлзийт суманд зохион байгуулагдаж 7 сумын ахмадууд уулзалдаж, спорт болон урлагийн тэмцээнүүд явагдсан байна. Төрсөн нутаг орондоо очиж чадалгүй, боломжгүй ахмадуудад зориулан "Нутгийн бараа" цогц ажил арга хэмжээний эхлэлийн хүрээнд энэ жил 2 ахмадыг нутагт нь очуулж нутгийн ах дүүстэй нь уулзуулах ажлыг зохион байгуулжээ. Залуу насандаа ажил хөдөлмөр, спортын амжилтаараа хамт олноо манлайлж явсан ахмад үеийн тамирчдыг алдаршуулах зорилгоор Ахмадын анхдугаар Спорт наадмыг аймагтаа зохион байгуулж, 18 сум, аймгийн төвийн 7-н баг, Номун далай сургуулийн ахмадын баг, Эрдэм сургуулийн ахмадын баг, СЗДТГазрын ахмадын баг, Цагдаагийн газрын ахмадын багууд оролцож, давхардсан тоогоор 983 тамирчин оролцсон байна.

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2018 оны зорилтот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
20	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	8.1	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	10	205.5	205.5	Баянхонгор аймгийн БОАЖГ-ын даргаар ахлуулан бүх сумын байгаль хамгаалагч нарыг хамруулж ховор амьтдын усан хангамжийг нэмэгдүүлэх, усны нөөцийг хуримтлуулах зорилгоор Баянбулаг сумын Сангийн далай 1-р багийн "Ар ногоон дугуйд" 16м урттай 1м өргөнтэй, 1.50м өндөртэй борооны ус, үерийн ус цуглуулах ховор амьтдын усан хангамжийг нэмэгдүүлэх, усны нөөцийг хуримтлуулах зорилгоор хөв, далан байгуулах ажлыг сумдын байгаль хамгаалагчдын хүчээр 2018 оны 06 сарын 05 – 08 хооронд хийж гүйцэтгэсэн байна. Өлзийт сумын 4 дүгээр багийн нутаг Намгийн голд тус багийн дарга С.Лувсанцэрэн бэлчээр хамгаалах зорилготой төсөл ирүүлснээр дэмжигдэж тус багт үйл ажиллагаа явуулдаг "Талын нөмөр" ХХК-тай хамтран хуучин гол урсаж байсан газарт хайраг дүүрсэн байсныг ухаж голдиролд оруулан үерийн ус чөлөөтэй урсах боломжийг бүрдүүлэн ус хальж болох газруудад 65м урт, 1м өндөр 2м өргөнтэй далан барилуулжээ. Аймгийн Нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 140 тоот заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн засаг даргын захирамжын дагуу Нэн ховор, ховор амьтдыг төлөөлүүлэн говийн гайхамшигт зургаан амьтныг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах, олон нийтэд сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар говийн экосистемийн хамгаалах талуудыг татан оролцуулах цаашид үйл ажиллагаанд нэгтгэхэд зорилгоор Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар, БОАЖГ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачилгаар "Говийн гайхамшигт-6" гуравдугаар зөвлөгөөнийг Шинэжижиг сумын "Эхийн голд" 2018.09.30-2018.10.03-ний хооронд зохион байгууллаа. БОАЖГ-ын дэргэдэх Экологийн танхим нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар Байгаль орчны хууль тогтоомж, түүний хэрэгжилт болон ирэгдэд экологийн боловсрол олгох ажлыг БОНХАЖЯам, Аймгийн ЗДТГ-гаар, ХБХалтэс, ХҮДСургууль, ЕБСургуулиуд, Цэцэрлэгүүд, сумдын тамгийн газар, багийн Засаг дарга, иргэд, ААН байгууллагуудтай хамтран ажилласан байна. Тус танхим нь иргэдэд Экологийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн боловсрол олгох чиглэлээр нийт 18 төрлийн 93 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, 41 удаагийн сургалт 1157 иргэнд экологи, ногоон хөгжлийн мэдлэг олгожээ. Тухайлбал: 41 сургалт зохион байгуулж 1157 иргэдийг хамруулж, 910 ширхэг брошур тараасан, эко клубуудын уулзалт, сургалтыг 6 удаа явуулж давхардсан тоогоор 360 суралч хамруулж, АХА тэмцэл зохион байгуулж, байгаль хамгаалах аяныг 3 удаа, үзэсгэлэнг 2 удаа, гар зургийн уралдааныг 2 удаа, эко клубын суралцдын явган аяллыг 3 удаа, цэцэрлэгийн хүүхдүүдийн явган аяллыг 1 удаа тус бүр зохион байгуулсан байна.
21		8.2	Байгаль хамгаалах үйл ажиллагаа		409.6	409.6	Эхний хагас жилийн байдлаар газрын даргын удирдамжын дагуу 4 удаа хяналт шалгалтыг хийж гүйцэтгэжээ. 2018.04.14 нд Аймгийн уул уурхайн зөвлөлгөөний зохион байгууллаа. "Уул уурхайн зөвлөлгөөн"-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгууллаа. Энэ жилийн уул уурхайн зөвлөлгөөний онцлог нь Уул уурхайн талаар төрөөс баримтлаж байгаа бодлогын талаар мэдээллийг хийж, зөвлөлгөөнөөс ашиглалтын, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхлэгч, аймгийн Засаг дарга, бүх шатны нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Засаг дарга, бусад албан тушаалтнуудад хандсан зөвлөмжийг гаргасан. "Мазаалай" телевиз, "Улсын бүртгэлийн халтэс", Баянхонгор сумын ЗДТГ, 6-р цэцэрлэг, Соого Сейжо сургууль, ТББ-уудын удирдлагуудад нийт 135 иргэдэд "Ногоон ажлын байр" сургалтыг зохион байгууллаа. Эрдэнэцогт сумын ойн сан бүхий Бугат, Цагаан мааньт, Хөх гол, Эрхт, Тамч зэрэг газруудад хууль бусаар мод тасалсан мэдээллийн дагуу Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэнтэй хамтран шалгалт хийжээ. Аймгийн Баганат талбайд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, тарьц, суулгалцын үзэсгэлэнг 5 аж ахуйн нэгжтэй хамтран гаргажээ. Бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр 70 аж ахуйн нэгж байгууллагын 820 иргэн оролцож, сум тойрсон ойн зурвас дахь хуваарьт талбайд нөхөн тарилт хийж, урд жилүүдэд тарьсан модыг арчилж, хашаа хамгаалалтыг сайжруулан, эвдэрсэн хайсыг засварлаж, ойр орчмын хог хаягдалыг цэвэрлэж, нүхэнд хуримтлагдсан элсийг гарган нийт 5669 мод сөөг тарьж усалгаа арчилгааг хийжээ. Тус ажлын хүрээнд Богд сумын мод үржүүлгийн газарт Өмнөговь аймгаас сувагц суулгац 500 ширхэгийг авч ирэн тарьсан байна. Баянхонгор аймгийн Дунд булаг, Цагаан чулуутай булаг, Өлзийт сумын Оготонтэй булгийн эхийг 2018 оны байдлаар хашаа хамгаалсан. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, зоогийн газар, амралт рашаан сувилал, жуулчны баазын үйл ажиллагаанд усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын дэглэмийг мөрдөж буй байдал, хууль тогтоомж, станцартын хэрэгжилтийг хянаж, шалгах ажлыг 2018 оны 08 дугаар сарын 21-28-ны хооронд Шаргалжуут, Баянлиг, Баянговь, Баацагаан, Галуут, Эрдэнэцогт сумдад хийсэн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хянах байгаль орчны засаглал төсөлтэй хамтран "Уул уурхайн байгаль орчны хамгаалал, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын тооллого" сэдэвт уулзалт, семинарыг 2018 оны 4 дүгээр сарын 02-07-ны өдрүүдэд БОАЖЯ-ны харьяа Цэнгэг ус, байгаль хамгаалах төвийн байранд зохион байгууллаа. Баянхонгор аймгийн эвдэрсэн газрын тооллогыг хийжээ. Аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар нийт 28 иргэн аж ахуй нэгж байгууллага Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэжээ. "Гялгар уулыг халья" уриан доор аймгийн төвийн дэлгүүрийн худалдагч болон даавуун торны төсөл авсан иргэдтэй уулзалт хийсэн байна.



д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2018 оны зорилгот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
22		8.3	Төрийн албаны стандартыг мөрдөж, төрийн албан хаагчийн ёс хэм хэмжээг сахиж үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх үзүүлэлтийг хангаж ажиллана.	45		22.9	22.9	Газрын ажилтан, албан хаагчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр дүгнэж, албан хаагчдад жилийн эцсийн байдлаар ажлын үр дүнг тооцож урамшуулал олгох, хариуцлага тооцохоор шийдвэрлэсэн. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор Баян-Овоо, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдын байгаль хамгаалагч нарт шинэ мотоцикл өгч хяналт шалгалт хийх нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллаж байна. Баянговь сумын ЗДТТ азартай хамтран Говийн сумдын байгаль хамгаалагчдыг чадаажуулах сургалтыг 10 сард багтаан зохион байгуулсан байна.
23	Өрхийн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүд	9.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Үйлчлэх хүрээний хүн ам		5,589.7	5,589.7	2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагааг төлөөлөн НБХ-ийн даргаар батлуулж хэрэгжүүлсэн байна. Аймгийн хэмжээний 20 сумын 56312 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг 25 нэгжээр дамжуулан хүргэж, эхний 9 сарын байдлаар 197 779 удаагийн үзлэгийн 49833 болуу 25.2% -ийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж, 60 001 өвчлөл бүртгэгдсэний 67.2% нь шинээр бүртгэгдсэн өвчлөл байна. Аймгийн хэмжээнд 1530 төрсөн эхийн 10.06% сумдын эрүүл мэндийн төвд төрж, нялхсын эндэгдэл урд оны мөн үеэс 3.0 пунктээр буурсан ч 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 63.1% нь суманд эндсэн үзүүлэлт гарчээ. СЭМТ-өөс иргэдийн заавал мэдвэл зохиох эрүүл мэндийн зайлшгүй швардлагатай мэдээллээр хангаж, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг тасралтгүй явуулж байгаа боловч иргэдийн болгоомжгүй, хайхрамжгүй байдлаас болж осол гэмтлийн өвчлөл урд оны мөн үеэс 10 000 хүн амд 12.0-оор өсч, осол гэмтлийн 66.9%-ийг эрчүүд, эзэлж, 15 хүртэл насны хүүхдийн 169 хүүхдийн 41.4%-ийг 0-5 хүртэл насны хүүхэд эзэлж байна. "Эрүүл хооллолт-Идэвхитэй хөдөлгөөн аян"-ы хүрээнд "Хүнсний бүтээгдэхүүний сонголт ба хадгалалт" сургалтыг 20 эрүүл мэндийн ажилтанд, 270 эцэг эхчүүд, "Боловсрол соёл урлагийн газар", "Хот тохижилт орон нутгийн өмчит үйлдвэрийн газар", "Эрчим хүч ХХК", "Музей"-н 140 албан хаагчдад мэдлэг олгож, мэдээлэл хүргэсэн. Нарны алхалтыг 7 хоног бүрийн бямба гаригт зохион байгуулж хэвшсэн. "Идэвхитэй хөдөлгөөн урт нас" аян өрнүүлж, "Насны баясгалан оч" ТББ-тай хамтран 20 сумын албан байгууллага, ЭМТ-тэй хамтран 5600 гаруй иргэдэд идэвхитэй хөдөлгөөний ач тус эрүүл байхын ач тус сэдвээр сургалтыг зохион байгуулж, 2018 оны 5дугаар сард Говийн бүсийн 7 сумын 30 багт төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын багийг ажиллуулах удирдамж төлөвлөгөөг боловсруулж үзлэгт 30 багийн 1867 иргэн хамрагдаж 540 иргэнд /БЗДХ, В, С вирус, сахар, шээс/ шинжилгээ хийж В вирустай-30, С-вирустай 17, бөөр шээсний замын эмгэгтэй 100 иргэн оношлогдож эмчилгээнд хамруулсан байна. Эрт үеийн цус алдалттай 2 эмэгтэй эмчилж II шатлалын эмнэлэгт, элэгний эмгэгтэй 1, зүрхний төрөлхийн гажигтай 1 хүүхдийг тус тус оношилж II шатлалд шилжүүлж эмчилгээнд хамруулан ажиллажээ.
24		9.2	Нийгмийн эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Өрх сумдын эрүүл мэндийн төвүүд иргэдийн дунд сар бүр 2 удаа сургалт сурталчилгаа зохион байгуулсан байх		84.1	84.1	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний 9 хөтөлбөр, 4 дэд хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн 32 тэмдэглэлт өдрийг 25 нэгжид сургалт, сурталчилгаа, мэдээлэл хийх, аян зохион байгуулах, гарын авлага тараах хэлбэрүүдээр зохион байгуулж, эхний хагас жилийн байдлаар үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт дунджаар 63.5%, дэд хөтөлбөрийн хэрэгжилт 69.5%-тай хэрэгжиж байна. "Элэг бүтэн Баянхонгор" дэд хөтөлбөрийг 2017-2020 хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын 2018 оны А/302 тоот захирамжаар батлуулж 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 4 зорилт, 9 зүйл заалтаар боловсруулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд Засаг даргын нөөцөөс 10.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. 2018 оны 5 сараас 15-39 насны залуучуудын II шатны үзлэгийг эхлүүлж 28903 иргэн хамрагдахаас 2153 /7.4%/ хамрагдаж үүнээс С вирус 46 /2.1%/, В вирус-100 /4.6%/ хүн өвчлөл илэрч эмчилгээнд хамрагдсан.
25		9.3	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлыг Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх	10 асуудал шийдвэрлэсэн байх		0.0	0.0	Анхан шатны тусламж үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлуудыг Засаг даргын зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсний дүнд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх унаны асуудлыг шийдвэрлэж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 7 сумын ЭМТ шинэ автомашин, 42 багийн эмчид мотоцикл, 76 багийн эмчийг яаралтай тусламжийн цүх, багцаар хангаж, багийн эмч, яаралтай тусламжийн жолооч, үйлчилгээний ажилтнуудын зөвлөгөөнийг тус тус зохион байгуулснаар тусламж үйлчилгээг хугацаа алдалгүй, чанартай үзүүлэх нөхцлийг бүрдүүлж ажиллажээ.
26		10.1	Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратегийг хэрэгжүүлэх үйлчилгээ	8 стратеги зорилтын хүрээнд 16 ажлыг зохион байгуулах				
27		10.2	Хүүхдийн оролцоог дэмжих стратеги	5 стратеги зорилтын хүрээнд 18 ажлыг зохион байгуулах				

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2018 оны зорилтот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/					
28	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс	10.3	Хүүхдийн хөгжил төлөвлөлийг сайжруулах цогцолбор хөтөлбөр	8 зорилтын хүрээнд 25 төсөлт ажил хэрэгжүүлэх	328.2		2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 283 тоот албан бичгээр 2016-2017 онд хэрэгжиж дууссан хөтөлбөр тул биелэлтийг гаргах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн					
29		10.4	Хүүхэд хөгжүүлэх хөтөлбөр	3 зорилтот арга хэмжээг зохион байгуулах								
30		10.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр	5 зорилтот ажил үйлчилгээг зохион байгуулах								
31		10.6	Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг байгуулах	Жилд 4 удаа нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах								
32		10.7	Хамтарсан багийн үйл ажиллагааг өргөжүүлэх	Жилд 2 удаа төвлөрсөн арга хэмжээг зохион байгуулах								
33		10.8	Хүүхдийн асуудал эрхлэх хорооны ажлыг идэвхижүүлэх	Жилд 2 удаа томоохон арга хэмжээг зохион байгуулах								
34		10.9	ХӨУБ-ийн идэвхитэй сонгуультануудад зориулсан гарын авлага хэвлүүлэн багш, сурагчдын хүртээл болгох	4000 ширхэг гарын авлага хэвлүүлж, удирдлага арга зүйгээр ханган ажиллана.								
35		10.10	Ажил идэвхитэй хайж буй залуучуудын нийгмийн идэвхийг сэргээх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Сард 1 удаа залуучуудад зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах								
36		Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	11.1	Газар төлөвлөлтийг зохион байгуулах удирдлага арга зүйгээр хангах				1200	821	366.3	366.3	Аймгийн иргэн болон аж ахуй нэгж байгууллагуудын газар өмчлөх, эзэмших, ашиглах хүсэлтийн дагуу тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ГХБХБГ-ын мэргэжилтэнгүүд "Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" болон "Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-нд нийцүүлэн төлөвлөж иржээ. Баянхонгор аймгийн ИТХ-ын 2018 оны 34 дүгээр тогтоолоор 2018 оны аймгийн "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө", 2018 оны 51 дүгээр тогтоолоор "Газар зохион байгуулалтын нэмэлт төлөвлөгөө", 2018 оны 83 дугаар тогтоолоор "Газар зохион байгуулалтын нэмэлт төлөвлөгөө"-г тус тус батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2018 оны 34, 51, 83 дугаар тогтоолоор нийт 47 нэгж талбарт төрийн байгууллагын хэрэгцээнд шинээр газар эзэмшүүлэх, эзэмшиж байгаа газрыг сунгах, газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулахвар батлагдсан байна. Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд 118 бүтээгдэхүүн тусгагдсанаас 26 бүтээгдэхүүн 90 хувь, 31 бүтээгдэхүүн 70 хувь, 18 бүтээгдэхүүн 50 хувьтай, 23 бүтээгдэхүүн 30 хувьтай, 19 бүтээгдэхүүн 10 хувьтай, 1 бүтээгдэхүүн хэрэгжээгүй байна. Газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага худалдаагаар 6 нэгж талбарын 1.37 га газрыг 156.4 сая, дуудлага худалдааны анхны үнээр 10 нэгж талбарын 0.41 га газрыг иргэн аж ахуй нэгжүүдэд 13.8 сая төгрөгөөр худалдаж, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, төрийн байгууллагын хэрэгцээнд засаг даргын захирамжаар 8 нэгж талбарыг 1.8 га газрыг эзэмшүүлсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 35 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд 2018 онд иргэнд газар өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг тогтоосон байна. 2018 онд 691 иргэн 54,44 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар 227 иргэнд 14,9 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн байна.

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2018 оны зорилтот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, тахилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
37		11.2 Барилга угсралт их засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлыг зохион байгуулах	350	215	35.7	35.7	<p>Аймгийн хэмжээнд барилгын материалын 19 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс бетон зуурмагийн 4 үйлдвэр, хуванцар цонх хаалганы үйлдвэр 7, тоосгоны 1, бетон гулдмайн 7 үйлдвэр үйл ажиллагаа тогтмол явуулж байна. Засгийн газрын 2012 оны 171 дугаар тогтоол Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсэхэд өөрийн лабораторид шинжилгээнд хамруулж, мөн хагас бүтэн жилээр бусад мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтарсан үзлэг шалгалтыг газрын даргын 2018.05.25-ны өдрийн үзлэг, шалгалт явуулах ажлын удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн улсын байцаалттай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдэд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-ийн хэрэгжилтийн хяналт, Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны БНБД 12-04-06, БНБД 12-03-04 дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөн туслах үйл ажиллагааг явууллаа. Тус үзлэг шалгалтад 4 иргэн, 8 аж ахуй нэгж хамрагдсан байна. Уг шалгалтаар нийтлэг илэрсэн зөрчлүүдээс дурдвал: Ажил олгогч нь ажилчдад ажлын нөхцөл онцлогт тусгай хувиас хамгаалах хэрэгсэл /тоосны хошуувч, бээлий, гутал, нүдний шил/-ээр хангаагүй, цахилгаан багаж тоног төхөөрөмжтэй хамгаалах хэрэгсэлгүй харьцаж байсан учир тухай бүрт зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай 16 барилга байгууламжид хяналт шалгалт хийсэн бөгөөд одоогоор Баянхонгор аймагт Сур харвааны барилга, Галуут, Баянбулаг сумд багийн төвийн 2 барилга, Баянхонгор аймагт орон сууцны 7 байрны засварын ажил, Жаргалант суманд эмнэлгийн барилгын засварын ажлыг хийлгэж байнгын ашиглалтад хүлээж авчээ. Орон нутгийн болоод улсын хөрөнгө оруулалттай барилга байгууламжуудын гүйцэтгэлийн явц 70-80 хувьтай байна. Энэ онд аймгийн хэмжээнд шинээр баригдах нийт 26 барилга байгууламжид зураг төсөл боловсруулах даалгавар болон архитектур төлөвлөлтийн даалгаврыг гаргаж зураг төслийг хянаж, эсжэ болон ажлын зураг сургууль, цэцэрлэгийн 7, олон нийтийн 15, орон сууцны 3, шатахуун түгээх станцын зориулалтаар 2 барилга байгууламжийн зураг төслийг батлан, Барилга хөгжлийн төвийн зураг төсөл магадлалын хэлтсээр хянуулж экспертизийн дүгнэлт гаргуулахаар хүргүүлжээ.</p>	
38	Ерөнхий боловсролын сургууль	12.1 Бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээ /өдөр/	16823	16234	18,642.3	18,642.3	<p>ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг хичээлээс гадуурх сургалтын цагт оруулан 7 хоногт нэг удаа орж байна. Мэргэжил сонголтын талаар төгсөх ангийн сурагчид болон эцэг эхчүүдэд 6 удаагийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтад нийт 900 сурагч, 120 гаруй эцэг эх хамрагдлаа. Ерөнхийлөгчийн Тамгын газраас 12-р ангийн сурагчдад "Мэргэжил сонголт ба бидний ирээдүй" лекц сургалтыг зохион байгуулж 600 гаруй хүүхэд оролцож англи хэлний зуны сургалтад хамрагдахаар болсон. 4, 5-р сард 24 их, дээд сургуулийн лекц мэдээ, мэдээлэлд сууж давхардсан тоогоор 5600 гаруй хүүхэд хамрагдсан байна. Англи хэлний гүнзгийрүүлсэн сургалттай англи Номундалай сургуулийн 6,7-р ангид 2 бүлэг, Номгон сургуулийн 6-9-р ангид 4 бүлэг, Эрдэм сургуулийн 6-р ангид 1 бүлэг, Эрдэнэмандал сургуулийн 6,7-р ангид 2 бүлэг тус тус хичээллэж 9 бүлэгт 224 сурагч хамрагджээ. Сургууль, цэцэрлэгийн багш, сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нараас авах мэргэжлийн түвшин тогтоох шалгалтын журмыг боловсронгуй болгож шинэчлэн аймгийн Засаг даргын 2018 оны А/252 дугаар захирамжаар батлуулан хэрэгжүүлж байна. Гурав дахь удаагийн шалгалтад 805 хүн хамрагдсан ба А-17, В-75, С-123, D-282, F-308, амжилт 61,74 хувь, чанар 11,43 хувьтай шалгагдсан байна.</p>	
39		12.2 Албан бус боловсролын үйлчилгээ	905	570	288.3	288.3	<p>2017-2018 оны хичээлийн жилд 682 суралцагч суралцсанаас бага боловсролд 58, суурь боловсролд 345, бүрэн дунд боловсролд 279 суралцагч суралцаж бага боловсролыг 15, суурь боловсролыг 59, бүрэн дунд боловсролыг 84 суралцагч эзэмшиж дараагийн шатны сургалт, сургуульд хамрагдах боломж нөхцөл бүрдлээ. Бүрэн дунд боловсролоор 795 цагийн, суурь боловсролоор 753 цагийн, бага боловсролоор 553 цагийн сургалтыг танихмын болон бие даалтын хэлбэрээр зохион байгуулсан. Сургууль завсардсан хүүхдийн тоо жил бүр буурч байгаа нь боловсрол нөхөн олгох сургалтын суралцагчдын тоо цөөрөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна. Орон нутгийн иргэдийн боловсролын судалгаа, бичиг үсэг үл мэдэгч иргэдийн судалгаа, сургууль завсардсан хүүхдийн судалгаа авсан байна. Тус судалгааны үндсэн дээр насан туршийн боловсролын нэгжүүдэд зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Зөвлөмжинд сумын Засаг дарга, багийн засаг дарга нарын Боловсролын тухай хуулинд заасан үүргийн дагуу тэдний тусалцаа, дэмжлэгийг аван шинэ хичээлийн жилийн суралцагчдын бүртгэлийг хавар 5, 6 сард хийж, бага боловсролтой, боловсролгүй иргэдтэй биечлэн уулзаж дүйсэн хөтөлбөрийн агуулга, суралцах хэлбэр, боломж нөхцлийг танилцуулж ухваруулснаар суралцах сонирхолтой иргэдтэй гэрээ хийн ажиллаж сургалтын хөтөлбөрийг бүрэн ханган ажиллах чиглэлийг тусгажээ. Аймгийн Засаг даргын тамгийн газрын дэргэдэх цэргийн штабтай цэргийн насны залуучуудын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. 3. Насан туршийн боловсролын нэгжийн менежер, багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх ажилд анхаарч байна. 2018 оны 9 сард БСШУСЯ-ны дэргэдэх НТБҮТ-өөс "Холимог бүлгийн сургалтын арга зүй" сургалтад нэгжийн 30 менежер, багш хамрагдсанаар янз бүрийн насны, мэдлэгийн түвшин өөр өөр суралцагчдад холимог бүлгээр сургалт зохион байгуулах арга зүйд суралцан ур чадвараа нэмэгдүүлсэн байна.</p>	

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2018 оны зорилтот түвшин	2018 онд хүрсэн түвшин /урьдчилсан/	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/	Урьдчилсан гүйцэтгэл /сая төгрөгөөр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
40	12.3	Дотуур байрны үйлчилгээ	1823	1663	2,268.9	2,268.9	2018 оны эхний 9 сарын байдлаар аймгийн дүнгээр 24 сургуулийн дотуур байранд 1663 хүүхэд амьдарч байна. Дотуур байранд нийт 27 багш ажиллаж байгаагаас 19 нь багш мэргэжилтэй байна. Дотуур байранд нийт 195 ажиллагчид ажиллаж байгаа бөгөөд дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах, хүүхдэд ээлтэй байдлыг үнэлэх зорилгоор 34 үзүүлэлтээр орчны судалгааг 24 дотуур байрнаас авч нэгтгэн гадаад, дотоод орчин, хүний нөөц, хүүхэд хамгааллын орчин зэргийг хамруулсан байна. Ариун цэврийн байгууламж ДЗОУ-ын байгууллагын зорилтот орон нутаг болох Богд, Жинст, Баянцагаан сумдын дотуур байранд хийгдсэн, шинэ сум болох Баянлиг, Бууцагаан сум дотор ариун цэврийн байгууламжтай, сайжруулсан гадаа жорлон Бөмбөгөр, Жаргалант суманд хийгдсэн байна. Дотуур байрны багшийг чадваржуулах сургалтыг зохион байгуулж 24 багш хамрагджээ.	
41	Сургуулийн өмнөх боловсрол	13.1	Цэцэрлэгийн үйлчилгээ /өдрөөр/	5217	5176	9,111.9	9,111.9	Баянхонгор аймгийн хэмжээнд 2017-2018 хичээлийн жилд төрийн өмчийн 35, төрийн бус өмчийн 7, нийт 42 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж 5176 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа нь нийт хүүхдийн 89 хувийг хамарч өмнөх оныхоос 3,8 хувиар өссөн үзүүлэлтэй гарчээ. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн 72,2 хувь нь өдрийн ангид хамрагдсан байна. Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжлийг нь дэмжих нь хөтөлбөрт ажлыг Баянбулаг, Галуут, Эрдэнэцогт, Баянговь, Баянлиг, Баянхонгор сумын цэцэрлэгүүдэд хэрэгжүүлж, 294 өрхийн 301 малчдын хүүхдийг хамрууллаа. Эцэг эх, олон нийтийн оролцоонд сурилсан энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх Орон нутгийн боловсролын зөвлөлийг Галуут, Эрдэнэцогт, Баянбулаг суманд байгуулж, сургуульд элсэх насны алслагдсан малчдын 134 хүүхдийг гэр бүлийн орчинд нь хөгжүүлэхэд нэмэлт хэрэглэгдэхүүнийг цэцэрлэг багш нар хийн ашиглаж, сургалтын багц бэлтгэн эцэг эхтэй нь хамтран ажиллаж байна.
42		13.2	СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээ	1950	2658	382.9	382.9	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн 27,8 хувь нь хувилбарт сургалтад хамрагдаж байна. Хувилбарт сургалтад хамрагдсан байдлыг тодруулан авч үзвэл 469 хүүхэд ээлжийн бүлэгт, 1299 хүүхэд нүүдлийн бүлэгт, 422 хүүхэд явуулын багшийн үйлчилгээнд хамрагдсан байна. СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхдийн 3017 буюу 38,2 хувь нь малчдын хүүхэд, 52 буюу 0,6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2025 буюу 25,6 хувь нь цэцэрлэгт шинээр элсэн орсон нь өмнөх онтой харьцуулахад 3,5 хувиар илүү байна. Баянхонгор сумын амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой хэмээн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн судалгаагаар бүртгэгдсэн 39 өрхийн 2-6 хүртэлх насны 43 хүүхдийг 2,3,5,6-р цэцэрлэгүүдийн үндсэн бүлэгт, мөн хөгжлийн бэрхшээлтэй 12 хүүхдийг тухайн харьяалагдаж буй тойргийн цэцэрлэгт дараалал харгалзахгүйгээр хамруулах ажлыг зохион байгуулжээ.
ДҮН					48,228.5	46,300.6		

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер

Б.Должмаа

Б.Азбаяр

Д.Цэцэгмаа

6417143544  
54040067 9007423